



**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
БАЙНГЫН ХОРООНЫ
ТОГТООЛ**

2025 оны 12 сарын 23 өдөр

Дугаар 08

Улаанбаатар хот

**Хууль, тогтоолоор үүрэг, чиглэл болгосон Улсын Их Хурлын
шийдвэрийн биелэлттэй танилцсантай холбогдуулан
авах арга хэмжээний тухай**

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.3.4, 22.3.13 дахь заалт, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.7 дахь хэсэг, 16 дугаар зүйлийг үндэслэн Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хорооноос ТОГТООХ нь:

1. Байнгын хорооны тогтоолоор үүрэг, чиглэл болгосон шийдвэрийн хэрэгжилтийн явц, биелэлтийг үндэслэн бүрэн хэрэгжсэн, цаг хугацааны хувьд ач холбогдолгүй болсон, хүчингүй болсон, тухайн асуудлаар дахин шийдвэр гарсан, бодит шалтгааны улмаас хэрэгжих боломжгүй болсон энэхүү тогтоолын 1 дүгээр хавсралтад дурдсан Байнгын хорооны тогтоолын холбогдох заалтыг хяналтаас хассугай.

2. Байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд хамаарах хууль, тогтоолоор үүрэг, чиглэл болгосон цаашид хэрэгжилтэд нь хяналт тавих шаардлагатай хууль, Улсын Их Хурлын болон Байнгын хорооны тогтоолын жагсаалтыг 2 дугаар хавсралтаар баталсугай.

3. Цаашид хэрэгжилтэд нь хяналт тавих шаардлагатай хууль, Улсын Их Хурлын болон Байнгын хорооны тогтоолын биелэлтийн тайланг Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуульд заасан хугацаанд бүрэн гүйцэт ирүүлэхийг Засгийн газар, Улсын Их Хуралд ажлаа шууд хариуцан тайлагнадаг байгууллагад даалгасугай.

4. Хууль, тогтоолоор үүрэг, чиглэл болгосон Улсын Их Хурлын шийдвэрийг бүртгэх, тайлагнах, дүн шинжилгээ хийх, мэдээлэх үйл ажиллагааг цахимжуулах, шийдвэрийн биелэлтэд их өгөгдөл, хиймэл оюун ухаан ашиглан дүн шинжилгээ хийх, Байнгын хорооны тогтоолыг Засгийн газар болон холбогдох байгууллагад албан ёсны нэгдсэн системээр дамжуулан хүргүүлэх боломжийг судлан шийдвэрлэхийг холбогдох байгууллагад үүрэг болгосугай.

5. Засгийн газар, Улсын Их Хуралд ажлаа шууд хариуцан тайлагнадаг байгууллагад үүрэг, чиглэл болгосон шийдвэр гаргахдаа хэмжигдэхүйц, тодорхой, ойлгомжтой, биелэгдэхүйц, хугацаатай байх зарчимд нийцүүлэн, хэрэгжилт, үр дүнг бодитой үнэлэх боломжийг хангахад анхаарч ажиллахыг Улсын Их Хурал, Байнгын хороодод зөвлөсүгэй.

6. Хууль, тогтоолоор үүрэг, чиглэл болгосон Улсын Их Хурлын шийдвэрийн хэрэгжилтийг эрчимжүүлэх, хөгжлийн бодлогын баримт бичиг, байгууллагын

гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилттэй уялдуулж, биелэлтийг хангах, хяналтыг сайжруулах, хэрэгжилтийн ил тод байдлыг хангах, олон нийтийн оролцоо, хяналтыг нэмэгдүүлэх чиглэлээр тодорхой арга хэмжээ авч, үр дүнг 2026 оны хаврын ээлжит чуулганы хугацаанд танилцуулахыг Засгийн газар, Улсын Их Хуралд ажлаа шууд хариуцан тайлагнадаг байгууллагад даалгасугай.

ХҮНИЙ ХӨГЖИЛ, НИЙГМИЙН
БОДЛОГЫН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА



Б.НАЙДАЛАА

Боловсруулсан: Б.Энхмаа
Хянасан:
3%, Н.Сарнай

Handwritten signature

Монгол Улсын Их Хурлын Хүний хөгжил,
нийгмийн бодлогын байнгын хорооны
2025 оны 08 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт

**ХҮНИЙ ХӨГЖИЛ, НИЙГМИЙН БОДЛОГЫН БАЙНГЫН ХОРООНЫ БҮРЭН
ХЭРЭГЖСЭН, ЦАГ ХУГАЦААНЫ ХУВЬД АЧ ХОЛБОГДОЛГҮЙ БОЛСОН,
ХҮЧИНГҮЙ БОЛСОН, ТУХАЙН АСУУДЛААР ДАХИН ШИЙДВЭР ГАРСАН, БОДИТ
ШАЛТГААНЫ УЛМААС ХЭРЭГЖИХ БОЛОМЖГҮЙ БОЛСОН ТОГТООЛЫН
ЖАГСААЛТ**

№	Шийдвэрийн нэр, огноо, дугаар	Заалтын дугаар	Заалт
Бүрэн хэрэгжсэн:			
1	Засгийн газарт чиглэл өгөх тухай 2018.05.22 №14	1.6.4/	б.Нийгмийн халамжийн тухай хуулийн хүрээнд: зорилтот өрхийн хөгжил, хамгааллыг сайжруулах Үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардлагатай санхүүжилтийг жил бүрийн улс, орон нутгийн төсөвт тусгах;
2	Засгийн газарт чиглэл өгөх тухай 2018.06.22 №17	1.1/	Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 4 дүгээр сарын 18-ны өдрийн 216 дугаар тогтоолын 2 дахь заалтад туссан Мэргэжлийн боловсрол, сургалтын үнэлгээний төвийн өөрийн үйл ажиллагааны орлогоос санхүүжих эрх зүйн орчныг бүрдүүлэх талаар санал боловсруулах, хууль, эрх зүйн орчныг бий болгох;
		1.2/	мэргэжлийн боловсрол, сургалтын олон эх үүсвэр бүхий санхүүжилтийн тогтолцоог бүрдүүлэх хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгож, хэрэгжилтийг хангах;
		1.4/	мэргэжлийн боловсрол, сургалтын нийгмийн түншлэлийн хүрээнд мэргэжилтэй ажилтан бэлтгэх, мэргэшлийн ур чадварыг өндөршүүлэх, суралцагчийг ажлын байранд дадлагажуулах, төгсөгчдийг ажлын байраар хангах зорилгоор аж ахуйн нэгжийн нийгмийн хариуцлагыг дээшлүүлэх хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлэх;
3	Хүүхдийн эрхийн тухай, Хүүхэд хамгааллын тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай 2018.12.20 №24	1.5/	эцэг, эх болон хүүхдийн асуудал хариуцсан бүх шатны төрийн байгууллагын ажилтан, албан хаагчдын мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх, мэргэшүүлэх ажлыг зохион байгуулах;
		1.7/	цагдаагийн байгууллагын бүтцэд хүүхдийг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр ажилладаг цагдаагийн алба хаагчийн орон тоог нэмэгдүүлж, төрийн байгууллагын хамтын ажиллагааг сайжруулах ажлыг шат дараалалтай хэрэгжүүлэх;
		1.8/	төрийн болон төрийн бус байгууллага, иргэдийг хүүхдийн эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд татан оролцуулах, хүүхэд хамгааллын асуудлаар тэдгээрээс гарсан санал, санаачилгыг дэмжих;
		1.9/	хүүхдийн эрхийг хангах талаарх төрийн захиргааны төв байгууллага, салбар дундын үйл ажиллагааг эрчимжүүлэх, уялдаа холбоог сайтар хангах, Хүүхдийн төлөө үндэсний зөвлөлийн үйл ажиллагааг тогтмолжуулж, гүйцэтгэлд тавих хяналтыг сайжруулах;
		1.10/	хэвлэл мэдээлэл, цахим орчин дахь хүүхдийн

			хөгжил, хүмүүжил, төлөвшилд сөрөг нөлөөтэй зураг, кино, дүрс бичлэг болон мэдээ, мэдээлэл, контентийг хянах, хаах зохицуулалтыг хууль, эрх зүй, технологийн түвшинд боловсронгуй болгож, хууль зөрчсөн этгээдэд оногдуулах хариуцлагыг чангатгах;
4	Засгийн газарт чиглэл өгөх тухай 2021.10.19 №05	1.1/	Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн 2021 оны 03 дугаар тогтоолыг эдийн засгийн нөхцөл байдал, технологийн үнэлгээ, судалгаанд үндэслэн шинэчлэн боловсруулан, 2022 оны 01 дүгээр сард багтаан ЭМДҮЗ-өөр батлуулж, Байнгын хороонд танилцуулах;
		1.3/	Эрүүл мэндийн даатгалын сангаас зардлын төлбөрийг нь хариуцах эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ, төлбөрийн хэмжээг Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөл нь баталдаг байх, одоо мөрдөгдөж буй тушаал, шийдвэрийн зөрчлийг арилгах;
		1.14/	Эрүүл мэндийн байгууллагуудад ашиглагдаж байгаа программ хангамжуудыг нэгтгэж, нэн даруй нэгдсэн мэдээлэл солилцооны платформд шилжүүлэх, цахим хяналтыг сайжруулах;
		1.15/	Эрүүл мэндийн салбарын худалдан авах ажиллагааг бүрэн цахимжуулах, ил тод нээлттэй байдлыг хангах, хяналтыг сайжруулах;
		2	Энэ тогтоолын биелэлтийг Монгол Улсын Их Хурлын Нийгмийн бодлогын байнгын хороонд УИХ-ын 2022 оны хаврын ээлжит чуулганы хугацаанд танилцуулахыг Монгол Улсын Засгийн газар /Л.Оюун-Эрдэнэ/-т үүрэг болгосугай.
5	Чиглэл өгөх тухай 2022.06.07 №14	1.1/	1.Ахмад настны тухай, Нийгмийн халамжийн тухай хуулийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газар /Л.Оюун-Эрдэнэ/-т чиглэл болгосугай: 1/Монгол Улсын Их Хурлын 2021 оны 12 дугаар тогтоолоор баталсан "Монгол Улсын хууль тогтоомжийг 2024 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл"-д заасны дагуу Нийгмийн халамжийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл, Ахмад настны тухай хууль болон холбогдох бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Улсын Их Хурлын 2022 оны намрын ээлжит чуулганаас өмнө Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх;
		1.2/	Ахмад настны тухай хуулийн 7 дугаар зүйлд заасан "Ахмад настанд үзүүлэх үйлчилгээ"-г үнэлэх, шинэчлэх, зарим төрлийн үйлчилгээг санхүүжүүлэх төсвийг "Ахмад настанд үзүүлэх үйлчилгээ, дэмжлэг, хөнгөлөлт"-ийн ангиллаас тусад нь "Ахмад настанд үзүүлэх үйлчилгээ" гэсэн зардлын ангилалаар нийгмийн халамжийн сангийн төсөвт тусгах;
		1.3/	Ахмад настны тухай хуулийн 14 дүгээр зүйлд заасан Ахмадын сангийн хэрэгжилтийг сайжруулах хүрээнд төсөвт байгууллагууд тухайн жилийн төсвийн төсөлдөө ахмадын санд төвлөрүүлэх хөрөнгийг тусган батлуулах, эрх зүйн орчинг боловсронгуй болгох;
		1.5/	Ахмад настны тухай хуульд заасан ахмадын зориулалттай амралт, сувиллын газрын эрхийн бичгийн нэг ор, хоногт нийгмийн халамжийн сангаас олгох хөнгөлөлтийн хэмжээг инфляцын өсөлттэй уялдуулан 2023 оноос нэмэгдүүлэхээр улсын төсөвт тусгах асуудлыг судалж, шийдвэрлэх;
		2	Энэ тогтоолд заасан холбогдох арга хэмжээг

				хэрэгжүүлэхэд шаардлагатай төсөв, хөрөнгийг 2023 оны улсын төсөвт тусгаж, санхүүжүүлэхийг Сангийн сайд /Б.Жавхлан/-д даалгасугай.
			3	Энэ тогтоолын биелэлтийг Монгол Улсын Их Хурлын Нийгмийн бодлогын байнгын хороонд 2023 оны 02 дугаар сарын 01-ний өдрийн дотор танилцуулахыг Монгол Улсын Засгийн газар /Л.Оюун-Эрдэнэ/-т үүрэг болгосугай.
6	Чиглэл өгөх тухай 2022.06.15 №18	1.4/		Аймаг, сум дүүргийн түвшинд хорт хавдрыг эрт илрүүлэх оношилгоо, шинжилгээнд шаардагдах тоног төхөөрөмж, хүний нөөцийг бэлтгэх санхүүжилтийг 2023 оноос эхлэн жил бүрийн улсын төсөвт тусган үе шаттайгаар шийдвэрлэх;
		3		Энэ тогтоолын биелэлтийг Монгол Улсын Их Хурлын Нийгмийн бодлогын байнгын хороонд 2023 оны 02 дугаар сарын 01-ний өдрийн дотор танилцуулахыг Монгол Улсын Засгийн газар /Л.Оюун-Эрдэнэ/-т үүрэг болгосугай.
7	Чиглэл өгөх тухай 2023.03.28 №05	1.2/		хүүхэд, гэр бүлийн асуудал хариуцсан нийгмийн ажилтныг бэлтгэх, орон тоог /1044/ шинээр бий болгох, цалинг ерөнхий боловсролын сургуулийн нийгмийн ажилтны жишигт хүргэх, цалингийн санд шаардагдах 17.6 тэрбум төгрөгийн санхүүжилтийг улсын төсөвт шат дараатай тусгах;
		1.3/		хүүхдийн эсрэг гэмт хэрэг, хүүхдийн бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэргийн хохирогч хүүхдийн сэтгэл санааны гэм хорыг үнэлэх, тооцох аргачлалыг яаралтай боловсруулах, хохирогчийн нийгэм, сэтгэлзүйн нөхөн сэргээх үйлчилгээнд үзүүлэх стандартыг тогтоох, хэрэгжүүлж ажиллах;
		1.4/		асрамж, халамжийн төв, түр хамгаалах байр, нэг цэгийн үйлчилгээний төвд ажиллах орон тооны сэтгэл зүйч, дохионы хэлний хэлмэрч, сэтгэл засалчийг ажиллуулах, онлайнаар тус үйлчилгээг авах нөхцөлөөр хангах;
		1.9/		хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад хүүхдийн эрх, эрх чөлөөг зөрчихгүй байх, хүүхдээс мэдүүлэг авахад зориулж тусгайлан бэлтгэсэн өрөө бий болгох, хүүхдийн эрхийг хамгаалсан бодлогыг хэрэгжүүлж ажиллах, бэлгийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэргийн хохирогч хүүхдээс мэдүүлэг авахдаа хохирогчтой ижил хүйсийн байцаагч ажиллуулах;
		1.12/		“Хөдөлмөрийн тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.3 дахь хэсэгт заасан байгууллага бүр хүүхэд хамгааллын бодлого хэрэгжүүлэх заалтын хэрэгжилтийг хангуулах хүрээнд Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газраас хүүхэд хамгааллын бодлого, түүний боловсруулалтын талаар зөвлөмж гаргаж байгууллагуудад хүргүүлэх.
		2.4/		Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын 2016-2022 оны санхүүгийн тайланд аудит хийлгэх, жил бүр хөндлөнгийн хяналт оруулах;
8	Шинжлэх ухаан, технологийн салбарын үйл ажиллагааг дэмжих зарим арга хэмжээний тухай 2017.02.16 №17(04)	1.1/		Шинжлэх ухаан, технологийн талаар төрөөс баримтлах бодлогын баримт бичгийг Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тухай хууль, Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр, түүнийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөнд нийцүүлэн боловсруулж, 2017 оны 2-р улиралд багтаан Засгийн газрын хуралдаанаар хэлэлцэн

9	Засгийн газарт чиглэл өгөх тухай 2017.06.09. №24		баталж, хэрэгжилтийг хангаж ажиллах;
		1.6/	Шинжлэх ухаан, технологийн салбарт ажиллагсдын цалин хөлс, нийгмийн баталгааг үе шаттай нэмэгдүүлэх, төсвийн байгууллагын цалингийн сүлжээнд өөрчлөлт оруулах замаар эрдэм шинжилгээний ажилтнуудын цалин хөлсийг төрийн өмчит их, дээд сургуулиудын багш, профессорын жишигт хүргэх, залуу эрдэмтэн, судлаачдыг дэмжих бие даасан хөтөлбөр баталж, хэрэгжүүлэх;
		1.10/	Шинжлэх ухаан, технологийн салбарт тулгамдаж буй, нэн тэргүүнд шийдвэрлэх шаардлагатай асуудлыг одоо хүчин төгөлдөр мөрдөгдөж буй эрх зүйн орчны хүрээнд шийдвэрлэх, Хууль тогтоомжийн тухай хуульд нийцүүлэн холбогдох хууль тогтоомжид нэмэлт, өөрчлөлт оруулах санал боловсруулан Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх.
		1.1/	Боловсролын багц хуулийн төслийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулан, 2017 оны намрын чуулганы хугацаанд УИХ-д өргөн мэдүүлэх;
		1.2/	"Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал – 2030 батлах тухай" болон "Төрөөс боловсролын талаар баримтлах бодлого батлах тухай" УИХ-ын тогтоолд заасан боловсролын салбарт хэрэгжүүлэх зорилтыг хангах талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээг жил бүрийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлд тусган, шаардагдах хөрөнгийг тухайн жилийн улсын төсөвт тусган баталж, хэрэгжүүлэх;
		1.3/	Салбарын хөрөнгө оруулалтын үр нөлөөг дээшлүүлж, ашиглалтын хугацаа дууссан, ашиглах боломжгүй болсон сургууль, дотуур байр, цэцэрлэгийн барилгын судалгаа, бүртгэлийг нарийвчлан гаргаж, улс, орон нутгийн төсөв, олон улсын төсөл, хөтөлбөрийн хүрээнд санхүүжүүлэн барьж, байгуулах ажлыг эхлүүлж, үе шаттайгаар хэрэгжүүлэх;
		1.4/	Тусгай хэрэгцээт боловсролын сургууль, цэцэрлэгийг Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яамны харьяалалд хууль тогтоомжид заасны дагуу яаралтай шилжүүлэх, Боловсролын асуудал эрхэлсэн эрдэм, шинжилгээ, арга зүйн байгууллага нь хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн хөгжил, боловсрол, сургалт, арга зүйн сектортой болох, нийслэлийн Боловсролын газар, аймгийн Боловсрол, соёл, урлагийн газарт хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн боловсролын асуудал эрхэлсэн орон тоог бий болгох, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг боловсролд тэгш хамруулан сургах талаар баримтлах бодлого боловсруулж, батлан мөрдүүлэх, энэхүү бодлогын хүрээнд тусгай хэрэгцээт сургууль, цэцэрлэгт ажиллаж байгаа багш ажилтны нийгмийн асуудал, ердийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн хөгжийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллаж буй багшид нэмэгдэл хөлс олгох зэрэг асуудлыг судлан шийдвэрлэх;
		1.7/	Олон улсын хөтөлбөрийн сургалттай ерөнхий боловсролын лаборатори Монгол тэмүүлэл, Шинэ эхлэл сургуулийг тус тус сурч боловсрох орчныг хангасан зориулалтын хичээлийн байртай болгох, эрэлт хэрэгцээнд нийцүүлэн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх арга хэмжээ авах;
		1.8/	Гүнзгийрүүлсэн сургалттай ерөнхий боловсролын сургуулийг их, дээд сургуулиудын лицей сургууль,

			багшлах боловсон хүчнийг давтан сургах, мэргэшүүлэх бааз суурь болгох эрх зүйн орчныг бий болгох, дээрх сургуулиудын сургалтын хураамжийн тодорхой хэсгийг сургууль өөрийн үйл ажиллагааг сайжруулах зорилгоор зарцуулах санхүүгийн боломж нөхцөлийг бий болгох;
		1.9/	Боловсролын салбарт бодит хөрөнгө оруулалт хийж байгаа төрийн бус өмчийн сургуулиудыг дэмжих бодлого боловсруулах, багш, ажилтнуудад олгох тэтгэвэр, тэтгэмж олгох эрх зүйн орчин бий болгох асуудлыг судлан шийдвэрлэх;
		1.10/	Боловсролын үнэлгээний төвийн бие даасан хараат бус байдлыг хангах, шалгалтын даалгаврын санг байгуулах замаар шалгалтын даалгаврын нууцлалтай холбоотой олон нийтийн хардлагыг арилгах, шалгалтын бүртгэл, зохион байгуулалт, материал засах, дүн, оноог мэдээлэх, мэдээллийн сангийн баталгаатай, аюулгүй байдлыг хангах үйл ажиллагаанд шаардлагатай тоног төхөөрөмж, программ хангамжийг нийлүүлж, их, дээд сургуулийн элсэлтийн шалгалтын баталгаатай ил, тод нээлттэй шуурхай, байдлыг хангах;
		1.11/	Ерөнхий боловсролын сургууль сэтгэл зүйчтэй байх, дотуур байрны багшийн ээлжийн амралтын хоногийг бусад багш нартай адил байхаар эрх зүйн орчинг бий болгох;
10	Засгийн газарт чиглэл өгөх тухай 2017.07.05 №25	1.2/	нийслэлийн 75 цэцэрлэг, хөдөө орон нутгийн нэн шаардлагатай цэцэрлэгт өргөтгөл хийх;
		1.6/	шинээр барих цэцэрлэгийн хүчин чадлыг тухайн орон нутгийн хүн амын тоо, өсөлтийг харгалзан тогтоох, газрын асуудлыг шийдвэрлэх;
		1.10/	0-3 насны хүүхдийг асран харгалзах, сургаж хүмүүжүүлэх өнөөгийн бодит боломж, нөхцөл, эрх зүйн орчныг судалж, цаашид хэрэгжүүлэх арга хэмжээний талаар санал боловсруулж тус Байнгын хороонд танилцуулах;
11	Засгийн газарт чиглэл өгөх тухай 2017.07.05 №26 НББСШУБХ	1.a.5/	Байгууллага дэмжих санг дээд боловсролын сургалтын байгууллагын дэргэд байгуулах, сангийн зарцуулалт, хяналт тавих тогтолцоо, эрх зүйн орчин бий болгох;
		1.6.4/	Багш, судлаач, эрдэмтдийн бүтээлийн мэдээллийн сан, номын сангийн нэгдсэн сүлжээг бий болгох /БУМС/;
		1.6.5/	Багш, судлаач, магистр, докторын сургалтад суралцагчдын судалгааны ёс зүйг сайжруулах, бүтээлийн хуулбарлалтыг илрүүлэх системийг бүрдүүлэх;
12	Монгол Улсын консерватори /хөгжмийн дээд боловсролын байгууллага/-ийн талаар авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай 2018.05.15 №13	1.1/	Консерватори /хөгжмийн дээд боловсролын байгууллага/-ийг бага, дунд боловсрол, мэргэжлийн боловсрол, дээд боловсрол олгодог шаталсан сургалттай, сургалт-эрдэм шинжилгээний хэв шинжтэй их сургууль болгох, консерваторийн боловсрол эзэмшүүлэх зардлыг төр хариуцдаг байх эрх зүйн орчныг бүрдүүлэх;
		1.2/	сургалтын тоног төхөөрөмж, сургалтын орчны материаллаг бааз /хөгжмийн зэмсэг, номын сан, лингафоны кабинет зэрэг/-ыг бэхжүүлэх, сургуулийн хичээлийн зориулалтын барилга, байгууламжийн засвар үйлчилгээ, циркийн сургуулийн болон оюутны дотуур байр барих хөрөнгө оруулалтыг төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн багц болон гадаадын зээл, тусламжийн эх үүсвэрээс жил бүр үе

			шаттай төсвийн төсөлд тусган хэрэгжүүлэх;
		1.3/	Консерваторийн бага, дунд боловсрол, мэргэжлийн боловсрол эзэмшүүлэхэд нэг суралцагчид ногдох хувьсах зардлын дундаж нормативын хэмжээг сургалтын хөтөлбөр, онцлогтой уялдуулан ялгавартай тогтоож, жил бүр Засгийн газрын тогтоолд тусган шийдвэрлэж байх;
		1.4/	Дээд боловсролын санхүүжилт, суралцагчдын нийгмийн баталгааны тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.4.4 дэх заалтыг хэрэгжүүлэхэд Консерватори /хөгжмийн дээд боловсролын байгууллага/-д дэмжлэг, туслалцаа үзүүлэх;
		1.5/	Консерваторийн залуу багш нарыг гадаад, дотоодод мэргэжил дээшлүүлэх, магистр, докторын сургалтад Боловсролын зээлийн сан, Засгийн газар хоорондын хэлэлцээрийн хүрээнд тэтгэлэгт хамруулах болон багш, оюутныг олон улсын ижил түвшний консерваторид туршлага судлах, солилцоонд хамрагдах, гадаадаас багш, мэргэжилтэн урьж ажиллуулах талаар тусгайлсан хөтөлбөр боловсруулан баталж, хэрэгжүүлэх;
13	Соёл, урлагийн салбарын талаар авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай 2018.10.16 №21	1.4/	үндэсний соёлын биет болон биет бус өв, түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйл болон үл хөдлөх дурсгалт газрыг хадгалах, хамгаалах, сэргээн засварлах, гадаад дотоодод сурталчлах үйл ажиллагааг эрчимжүүлэх;
		1.5/	салбарын хүний нөөцийн хөгжлийн /2019-2023 он/ төлөвлөгөөг баталж, соёл, урлагийн салбарын ажиллагсдын цалин, урамшуулал, мэргэжлийн зэрэг, хөдөлмөрийн нөхцөл, нийгмийн баталгааг хангах чиглэлээр үе шаттай арга хэмжээ авч хэрэгжүүлэх;
		1.7/	соёлын бүтээлч үйлдвэрлэлийг хөгжүүлэх, дотоод болон гадаадад сурталчлан таниулах, олон улсын зах зээлд нэвтрүүлэх замаар эдийн засгийн эргэлтэд оруулах арга хэмжээг авч хэрэгжүүлэх;
14	Ерөнхий боловсролын сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний тухай хуулийн хэрэгжилтийг хангах зарим арга хэмжээний тухай 2021.05.25 №05	1.3/	нийслэл болон орон нутгийн боловсролын асуудал эрхэлсэн нутгийн захиргааны байгууллагад сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний бодлогыг хэрэгжүүлэх ажлыг хариуцсан орон тоог бий болгож, цалин хөлсний асуудлыг шийдвэрлэх;
		1.7/	төрийн болон орон нутгийн өмчит сургуулийн хоол үйлдвэрлэлийн зориулалт бүхий талбайг бусдад ашиглуулсан төлбөрөөс төвлөрүүлэх орлогыг 100 хувь тухайн сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний байрны засвар, тоног төхөөрөмжид зарцуулах эрх зүйн орчныг бүрдүүлж, хэрэгжилтийг ханган ажиллах;
		1.9/	ерөнхий боловсролын сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний өнөөгийн нөхцөл байдалд мэргэжлийн хяналтийн байгууллагаар үнэлгээ хийлгэж, санал дүгнэлтийг улсын хэмжээнд нэгтгэн гаргаж, цаашид үүсэж болох эрсдэлээс урьдчилан сэргийлэх чиглэлээр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө боловсруулж, хэрэгжилтийг хангах;
		1.11/	2022 оноос эхлэн хуулийн хэрэгжилтэд шаардагдах урсгал болон хөрөнгө оруулалтын зардлыг улсын төсөвт бүрэн тусгах, аж, ахуйн нэгж, байгууллагын хандив, олон улсын байгууллага, гадаад орнуудын буцалтгүй тусламжийн хүрээнд хууль тогтоомжид заасны дагуу шийдвэрлэх.
15	Биеийн тамир, спортын тухай хуулийн	1.2/	"Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогод нийтийн биеийн тамир, спортын

	хэрэгжилтийг хангах зарим арга хэмжээний тухай 2021.10.19 №08		талаар шинэ зорилтуудыг тусгаж, нийтийн биеийн тамир спортыг хөгжүүлэх бодлогын асуудлыг Монгол Улсын Ерөнхий сайдын эрхлэх асуудлын хүрээнд шилжүүлсэнтэй холбоотойгоор холбогдох хууль тогтоомжид нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлыг судалж, шийдвэрлэх;
		1.3/	"Парис-2024" зуны олимп, Паралимпын наадмын бэлтгэл ажил эхэлсэнтэй холбогдуулан оролцох Монгол Улсын Үндэсний шигшээ багийг шинээр сонгон шалгаруулах, эрх зүйн орчныг сайжруулах чиглэлээр холбогдох хууль тогтоомжид яаралтай нэмэлт, өөрчлөлт оруулж, УИХ-д өргөн мэдүүлэх
		1.4/	Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 9.1.12-т "магадлан итгэмжлэгдсэн спортын клубт идэвхтэй хөдөлгөөн, спортоор хичээллэх үйлчилгээ"-ний зардлын төлбөрийг Эрүүл мэндийн даатгалын сангаас хариуцдаг байсан зохицуулалтыг сэргээх асуудлыг судлах;
		1.10/	Олимп, дэлхийн тэмцээнүүдэд амжилт гаргасан тамирчдад олгож байгаа шагнал урамшууллын бодлогыг хүртээмжтэй болгох, тамирчны сахилга хариуцлага, нийгэмд үлгэрлэх байдалтай нь уялдуулж олгох байдлаар өөрчлөх арга хэмжээ авч хэрэгжүүлэх;
16	"Монгол Улсын 2021 оны төсвийн тухай хууль баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай" Улсын Их Хурлын 2020 оны 39 дүгээр тогтоолын 1 дэх заалтын 5 дахь дэд заалтын хэрэгжилтийг хангах зарим арга хэмжээний тухай 2022.01.17. №01	1.4/	захиалагчаас тогтоосон нөхцөл, техникийн тодорхойлолтын шаардлагыг хангасан зураг төсөв боловсруулах болон ажил гүйцэтгэчийг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуульд заасан журмын дагуу 2022 оны 4 дүгээр сард багтаан тус тус сонгон шалгаруулж, ажлыг эхлүүлэн гүйцэтгэлд хяналт тавих;
		2	Энэ тогтоолын хэрэгжилтийг зохион байгуулж, хагас жилийн ажлын тайланг 2022 оны хаврын чуулганы хугацаанд, жилийн ажлын тайланг 2022 оны намрын чуулганы хугацаанд Монгол Улсын Их Хурлын Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хороонд танилцуулахыг Монгол Улсын Засгийн газар /Л.Оюун-Эрдэнэ/-т даалгасугай.
Цаг хугацааны хувьд ач холбогдолгүй болсон			
18	Сүрьеэ, бэлгийн замаар дамжих халдварт өвчин, хүний дархлал хомсдолын вирусын халдварын тархалтыг бууруулах, хязгаарлах, урьдчилан сэргийлэх талаар авах арга хэмжээний тухай 2016.04.05 №10	3.1/	Харьяа нутаг дэвсгэрийн хэмжээнд сүрьеэ, бэлгийн замаар дамжих халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх ХДХВ/ДОХ-ын тархалтыг бууруулах, хязгаарлах тухай эрсдлийн удирдлагын хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах;
19	Бэлгийн замаар дамжих халдварт өвчин, хүний дархлал хомсдолын вирусын халдварын тархалтыг бууруулах, урьдчилан сэргийлэх талаар авах арга хэмжээний тухай 2016.12.14 №04	2.1/	Хүн амын дунд БЗДХ-т өвчин нэмэгдэж байгаатай холбогдуулан аймаг, нийслэл, дүүргийн түвшинд хэрэгжүүлэх хөгжлийн бодлогын баримт бичигтээ ХДХВ-ын халдвар, ДОХ болон БЗДХ-аас урьдчилан сэргийлэх асуудлыг тусгаж, хэрэгжилтийг хангах;
		2.2/	Нутаг дэвсгэрийнхээ хүн амыг эрүүл, аюулгүй орчинд амьдрах нөхцөлийг хангахад шаардагдах зардлыг жил бүрийн төсөвтөө тусгаж батлуулах, зарцуулалтад хяналт тавих.
20	Эрүүл мэндийн салбарын	2	Байнгын хорооны тогтоолын хэрэгжилтийг хангах

	бодлого, эрүүл мэндийн тухай хууль тогтоомжийг боловсронгуй болгох, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний тухай НББСШУБХ 2017.05.12 №22(09)		үүднээс хийх ажлын төлөвлөгөө гаргаж, жил бүрийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл болон улсын төсөвт тусгахыг БСШУС-ын сайд, Сангийн сайд, ХНХ-ын сайд, ЭМ-ийн сайд нарт даалгасугай.
		3	Тогтоолын хэрэгжилтийн явц, байдлын талаар НББСШУБХ-нд жил бүрийн 4 дүгээр улиралд багтаан танилцуулж байхыг Монгол Улсын Засгийн газарт, биелэлтэд хяналт тавьж ажиллахыг НББСШУБХ-д тус тус үүрэг болгосугай.
21	Засгийн газарт чиглэл өгөх тухай 2018.05.22 №14	3	Тогтоолын хэрэгжилтийн талаар Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хорооны хуралдаанд 2018 оны намрын чуулганы хугацаанд багтаан танилцуулахыг Монгол Улсын Засгийн газар /У.Хүрэлсүх/-т, биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хороо /Ё.Баатарбилэг/-нд тус тус үүрэг болгосугай.
22	Засгийн газарт чиглэл өгөх тухай 2018.06.22 №17	3	Тогтоолын хэрэгжилтийн талаар Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хороонд 2018 оны намрын чуулганы хугацаанд багтаан танилцуулахыг Монгол Улсын Засгийн газар /У.Хүрэлсүх/-т, биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хороо /Ё.Баатарбилэг/-нд тус тус үүрэг болгосугай.
23	Хүүхдийн эрхийн тухай, Хүүхэд хамгааллын тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай 2018.12.20 №24	1.3/	төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгжүүд ажилтныг хууль тогтоомжид зааснаас илүү цагаар ажиллуулахгүй байх нөхцөл боломжоор хангах, ажилтан, албан хаагчийн гэр бүл, үр хүүхэддээ зарцуулах цагийг олгодог байх, нийгмийн хариуцлагын үүднээс 2019 оныг "Хүүхэд хамгааллын жил" болгон зарлахыг уриалах;
		1.6/	хүүхдийг гэмт халдлагаас хамгаалах, гэмт хэрэгт өртөхөөс урьдчилан сэргийлэх, илрүүлэх чиглэлээр Цагдаагийн ерөнхий газраас санаачилж байгаа "Хүүхэд хамгаалагч" болон "Хүүхдийг зам тээврийн осол, гэмтлээс урьдчилан сэргийлэх бодит сургалт зохион байгуулах" төслийг 2019 онд хэрэгжүүлэх, санхүүжилтийг шийдвэрлэх, төслийн үр дүнгээс хамаарч шаардлагатай тохиолдолд цаашид жил бүр тухайн төслийн төсвийг улсын төсөвт тусгаж, хэрэгжилтийг тогтмолжуулах;
		2	Байнгын хорооны тогтоолын хэрэгжилтийг хангах үүднээс хийх ажлын төлөвлөгөө гаргаж, жил бүрийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл болон улсын төсөвт тусгаж, хэрэгжүүлж ажиллахыг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам /С.Чинзориг/-нд үүрэг болгосугай.
		3	Тогтоолын хэрэгжилтийн талаарх мэдээллийг улирал бүр, тайланг хагас жил тутамд Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хороонд танилцуулахыг Монгол Улсын Засгийн газар /У.Хүрэлсүх/, биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хороо /Ё.Баатарбилэг/-нд тус тус үүрэг болгосугай.
24	Засгийн газарт чиглэл өгөх тухай 2017.06.09. №24	1.6/	Боловсролын хүрээлэн, Боловсролын үнэлгээний төв, Насан туршийн боловсролын төвийн ажлын байрны нөхцөлийг сайжруулах асуудлыг шийдвэрлэх, Боловсролын хүрээлэнгийн эрдэм шинжилгээ, судалгаа, арга зүйн мэргэжлийн

		3	чадавхыг сайжруулах арга хэмжээ авч ажиллах; Тогтоолын хэрэгжилтийн талаар НББСШУБХ-ны хуралдаанд 2017 оны намрын чуулганы хугацаанд багтаан танилцуулахыг МУ-ын Засгийн газарт, биелэлтэд хяналт тавьж ажиллахыг НББСШУБХ-ны даргад тус тус үүрэг болгосугай.
25	Засгийн газарт чиглэл өгөх тухай 2017.07.05 №25	3	Тогтоолын хэрэгжилтийн талаар Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хорооны хуралдаанд 2017 оны намрын чуулганы хугацаанд багтаан танилцуулахыг Монгол Улсын Засгийн газар /Ж.Эрдэнэбат/, биелэлтэд хяналт тавьж ажиллахыг НББСШУБХ-ны дарга /Л.Энх-Амгалан/-д тус тус үүрэг болгосугай.
26	Засгийн газарт чиглэл өгөх тухай 2017.07.05 №26 НББСШУБХ	1.6.1/	Засгийн газраас дүрэм, журам, тогтоол гарган хуулийн хэрэгжилтийг хангах чиглэлээр: дээд сургуулийн судалгааны чадавх, үр өгөөжийг сайжруулах, үр дүнг нь хөдөлмөрийн зах зээлийн эргэлтэд оруулж инновацийн шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээ бий болгох, өндөр технологийн лабораторийг нийлүүлэх, хамтран ашиглах, судалгаа, шинжилгээний дэд бүтэц, лабораторийн нөхцөл байдлыг үнэлж, хүний нөөц, байгууллагын чадавх, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх, дэлхийн зах зээлд гаргаж улс орны өрсөлдөх чадварыг дээшлүүлэх чиглэлээр хөтөлбөр боловсруулж, хэрэгжүүлэх;
27	Монгол Улсын консерватори /хөгжмийн дээд боловсролын байгууллага/-ийн талаар авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай 2018.05.15 №13	2	Энэ тогтоолын дагуу авч хэрэгжүүлсэн арга хэмжээний биелэлтийг Улсын Их Хурлын Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хороонд 2018 оны 10 дугаар сарын 01-ний дотор танилцуулахыг Засгийн газар /У.Хүрэлсүх/-т, жил бүр биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хороо /Ё.Баатарбилэг/-нд тус тус даалгасугай.
28	Соёл, урлагийн салбарын талаар авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай 2018.10.16 №21	2	Энэ тогтоолын дагуу авч хэрэгжүүлсэн арга хэмжээний биелэлтийг Улсын Их Хурлын НББСШУБХ-нд 2019 оны 02 дугаар сарын 15-ны дотор танилцуулахыг Засгийн газар /У.Хүрэлсүх/-т даалгасугай.
29	Ерөнхий боловсролын сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний тухай хуулийн хэрэгжилтийг хангах зарим арга хэмжээний тухай 2021.05.25 №05	2	Энэ тогтоолын хэрэгжилтийн тайланг Монгол Улсын Их Хурлын Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хороонд 2021 оны 8 дугаар сарын 15-ны дотор танилцуулахыг Монгол Улсын Засгийн газар /Л.Оюун-Эрдэнэ/-т даалгасугай.
30	Биеийн тамир, спортын тухай хуулийн хэрэгжилтийг хангах зарим арга хэмжээний тухай 2021.10.19 №08	1.1/	Биеийн тамир, спортын тухай хуулийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд дараах арга хэмжээг шуурхай авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газар /Л.Оюун-Эрдэнэ/-т чиглэл болгосугай; 1/ Биеийн тамир спортын тухай хууль, МУЗГ-ын 2020-2024 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөр, түүнийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд биеийн тамир, спортын чиглэлээр тусгагдсан зорилт, арга хэмжээний хэрэгжилтийг МУЗГ, бүх шатны ИТХ, аймаг, нийслэлийн Засаг дарга, биеийн тамир, спортын Улсын хороо хангаж ажиллах;
		2	Энэ тогтоолын биелэлтийг Улсын Их Хурлын БСШУБХ-нд 2022 оны 02 дугаар сарын 10-ны дотор танилцуулахыг Засгийн газар /Л.Оюун-Эрдэнэ/-т үүрэг болгосугай.

31	"Монгол Улсын 2021 оны төсвийн тухай хууль баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай" Улсын Их Хурлын 2020 оны 39 дүгээр тогтоолын 1 дэх заалтын 5 дахь дэд заалтын хэрэгжилтийг хангах зарим арга хэмжээний тухай 2022.01.17. №01	1.1/	Дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газарт чиглэл болгосугай: 1/ төслийн 1, 2 дугаар ээлжийн барилга угсралтын ажлын зургийг холбогдох хууль тогтоомжид заасны дагуу баталгаажуулж, ажлын гүйцэтгэлийг хянан, тодорхой арга хэмжээ авч, ажлыг эрчимжүүлэх;
		1.2/	төслийн 3, 4 дүгээр ээлжийн барилга угсралтын ажлыг төлөвлөгөөт хугацаанд чанартай гүйцэтгэн дуусгаж, ашиглалтад оруулах ажлыг удирдан зохион байгуулах;
		1.3/	төсөлд нэг маягийн зураг, төсөв ашиглах бол холболтын зураг төсөл, тухайлсан байршилд шинээр зураг, төсөв боловсруулан гүйцэтгэхэд ажлын даалгавар, геологи, геодезийн дүгнэлт, байгаль орчны ерөнхий үнэлгээ, техникийн нөхцөлүүдийг хууль тогтоомжийн дагуу шуурхай олгох, мэргэжлийн байгууллагаар хянагдан магадлалын дүгнэлтээр баталгаажуулсан ажлын иж бүрэн зураг, төсвийг холбогдох байгууллагад 2022 оны 02 сарын 15-ны дотор хүргүүлэхийг Барилга, хот байгуулалтын сайд, Байгаль орчин, аялал жуулчлалын сайд болон аймгийн Засаг дарга нарт үүрэг болгох;
		1.5/	тухайн орон нутагт хэрэгжүүлж байгаа төсөл, хөтөлбөрийн бүтээн байгуулалтын явцад хяналт тавьж, хариуцсан чиглэлээр үүрэг, зөвлөмж өгч ажиллахыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт үүрэг болгох;
Шийдвэр хүчингүй болсон:			
32	Засгийн газарт чиглэл өгөх тухай 2018.06.22 №17	1.9/	2016-2021 онд хэрэгжүүлэх "Мэргэжлийн болон техникийн боловсролыг хөгжүүлэх Үндэсний хөтөлбөр"-ийг хэрэгжүүлэхэд шаардлагатай санхүүжилтийг жил бүрийн улс, орон нутгийн төсөвт тусгах;
34	Соёл, урлагийн салбарын талаар авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай 2018.10.16 №21	1.2/	Соёл, урлагийг дэмжих сан, Засгийн газраас баталсан соёлын хөтөлбөрийн хэрэгжилтэд шаардагдах санхүүжилтийг үе шаттай нэмэгдүүлэх, соёл, урлагийн салбарын санхүүжилтийг тухайн төсвийн жилийн дотоодын нийт бүтээгдэхүүний нэг хувиас доошгүй байхаар төлөвлөж байх асуудлыг судалж танилцуулах;
Шийдвэрт заасан хугацаа дуусгавар болсон:			
36	Засгийн газарт чиглэл өгөх тухай 2017.06.09. №24	1.5/	Цэцэрлэг, сургууль, дотуур байрны хоол, хүнсний хангамжийн эрүүл, аюулгүй байдлыг хангах, чанарыг сайжруулах талаар холбогдох арга хэмжээг хэрэгжүүлэх, "Үдийн цай" хөтөлбөрийг "Үдийн хоол" болгох эрх зүйн орчныг бий болгон шаардагдах төсвийг 2018 оны Улсын төсөвт тусган хэрэгжүүлэх;
37	Засгийн газарт чиглэл өгөх тухай 2017.07.05 №25	1.1/	нийслэлийн цэцэрлэггүй 25 хороонд цэцэрлэг барих асуудлыг 2017-2019 онд үе шаттай шийдвэрлэх;
Эрх зүйн орчин шинэчлэгдсэн:			
39	Хүүхдийн эрхийн тухай, Хүүхэд хамгааллын тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай 2018.12.20 №24	1.1/	1.Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хорооноос Хүүхдийн эрхийн тухай, Хүүхэд хамгааллын тухай хуулиудын хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газар /У.Хүрэлсүх/-т чиглэл болгосугай: 1/Хүүхдийн эрхийн тухай, Хүүхэд хамгааллын тухай хуулийн хэрэгжилтийг бүрэн хангаж ажиллах;
		1.2/	эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч нь хүүхдийн хөгжил, эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлж болзошгүй эрсдэлт нөхцөлөөс урьдчилан сэргийлэх,

			хамгаалах үүргээ хуульд заасны дагуу биелүүлэх талаар хуулийг таниулах ажил зохион байгуулах, биелүүлээгүй тохиолдолд хүлээлгэх хариуцлагын тогтолцоог чангатгах хууль, эрх зүйн орчныг бий болгох;
40	Чиглэл өгөх тухай 2022.06.07 №14	1.8/	Улсын хэмжээнд үйл ажиллагаа явуулдаг төрөлжсөн асрамжийн газрын барилга байгууламж, засвар, хөрөнгө оруулалтын шаардлагатай зардлыг улсын төсөвт тусган шийдвэрлэх, орон нутгийн дэмжлэгтэйгээр үйл ажиллагааг сайжруулах;
		1.11/	Ахмад настны эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний асуудлаар Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Эрүүл мэндийн яамны хамтын ажиллагааг эрчимжүүлэх.
41	Шинжлэх ухаан, технологийн салбарын үйл ажиллагааг дэмжих зарим арга хэмжээний тухай 2017.02.16 №17(04)	1.2/	Монгол Улсын Засгийн газрын 2014 оны 301 дүгээр тогтоолоор баталсан "Шинжлэх ухаан технологийн төсөл хэрэгжүүлэх журам", шинжлэх ухаан, технологийн салбарт Засгийн газраас батлан мөрдүүлж буй журам, зааварт үүссэн шинэ нөхцөл байдал, мэргэжлийн байгууллагаас гаргасан саналыг харгалзан өөрчлөлт оруулж, салбарын үйл ажиллагааны зохицуулалтыг уян хатан, боловсронгуй болгох;
		1.3/	Монгол Улсын Засгийн газрын "Шинжлэх ухааны байгууллагуудын талаар авах зарим арга хэмжээний тухай" 2015 оны 27 дугаар тогтоол, "Тогтоолд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай" 2015 оны 78 дугаар тогтоолын хэрэгжилтийг тус тус хянаж, шинжлэх ухааны байгууллагуудын бүтэц тогтолцоо, харьяалал өөрчлөгдсөнтэй холбоотой үүсч буй тулгамдсан асуудлыг 2017 онд багтаан судлан шийдвэрлэх, цаашид тогтолцоог оновчтой болгох;
		1.4/	Шинжлэх ухааны байгууллагуудын барилга байгууламж, үл хөдлөх хөрөнгөтэй холбоотой хөрөнгийн маргааныг холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн шийдвэрлэх, цаашид тухайн байгууллагуудын тогтвортой, хэвийн үйл ажиллагаа явуулах нөхцөлийг бүрдүүлэх;
		1.7/	Салбарын бодлого төлөвлөлтийг сайжруулах, салбар дундын уялдаа холбоог хангах, эдийн засгийн өсөлтөд шинжлэх ухааны үүрэг ролийг нэмэгдүүлэх, Шинжлэх ухаан технологийн Үндэсний зөвлөл болон яамдын дэргэдэх Шинжлэх ухаан технологийн зөвлөлийн үйл ажиллагааг идэвхжүүлэх, суурь судалгааны үр дүнг төрийн бодлого боловсруулах, шийдвэр гаргах үйл ажиллагаанд ашиглах арга механизмыг бүрдүүлэх;
		1.8/	Эрдэм шинжилгээ, судалгааны ажлын үр дүнг үйлдвэрлэл, практикт нэвтрүүлэх, биет бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг дэмжих зорилгоор тусгай зориулалтын сангийн үйл ажиллагааг идэвхжүүлэх, Монгол эрдэмтдийн бүтээсэн, дотооддоо үйлдвэрлэх боломжтой инновацийн бүтээгдэхүүнийг улсын төсвийн хөрөнгөөр худалдан авах ажиллагааг дэмжих;
		1.9/	Эрдэм шинжилгээ, судалгааны үйл ажиллагааг хэвийн явуулах, туршилт судалгаа хийх, үйлдвэрлэл практикт нэвтрүүлэх, эдийн засгийн эргэлтэд оруулах тусгайлсан дэд бүтэц, маркетинг, менежментийн тогтолцоог бүрдүүлэх;
42	Засгийн газарт чиглэл өгөх тухай 2017.07.05	1.а.1/	Хууль тогтоомжид нэмэлт, өөрчлөлт оруулах чиглэлээр: Их сургуулиудыг судалгаанд суурилсан

	№26 (13) НББСШУБХ		хэлбэрээр хөгжүүлэх эрх зүйн орчин бүрдүүлэх, санхүү, хөрөнгө оруулалтын зохих дэмжлэг үзүүлдэг болох;
		1.а.3/	Сургалтын үйл ажиллагааны чанарын шинэчлэлийн хүрээнд хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, хэрэгцээнд тулгуурлан сургалтын агуулга, арга зүйг сайжруулах, үнэлгээний аргачлалыг шинэчлэх "Үр дүнд суурилсан боловсрол"-ын тогтолцоог хөгжүүлэх эрх зүйн орчин бүрдүүлэх;
		1.в.1/	Боловсролын магадлан итгэмжлэлийн үйл ажиллагааны чиглэлээр: Боловсролын магадлан итгэмжлэлийн үйл ажиллагааны талаарх холбогдох хуулийн зохицуулалтын сайжруулах;
		1.в.2/	Магадлан итгэмжлэх байгууллага, хөтөлбөр магадлан итгэмжлэх байгууллага, Магадлан итгэмжлэлийн үндэсний зөвлөлийн эрх үүргийг холбогдох хууль тогтоомжид өөрчлөлт оруулан тодорхой болгох;
		1.в.3/	Олон улсад магадлан итгэмжлэгдсэн сургалтын байгууллага, сургалтын хөтөлбөрт дэмжлэг үзүүлэх талаар холбогдох хууль тогтоомжид өөрчлөлт оруулах;
43	Биеийн тамир, спортын тухай хуулийн хэрэгжилтийг хангах зарим арга хэмжээний тухай 2021.10.19 №08	1.12/	Нутгийн өөрөө удирдах байгууллага, бүх шатны засаг дарга харьяа нутаг дэвсгэртээ нийтийн биеийн тамирыг хөгжүүлэх, иргэдийн идэвхтэй хөдөлгөөн, спортоор хичээллэх нөхцөлийг бүрдүүлэх, спортын барилга байгууламж, заал, талбайн хүрэлцээ хангамжийг нэмэгдүүлэх, жил бүрийн улсын төсвийн төсөлд биеийн тамир спортын салбарын зардлыг нэмэгдүүлэх талаар анхаарч ажиллах.

Монгол Улсын Их Хурлын Хүний хөгжил,
нийгмийн бодлогын байнгын хорооны
2024 оны 08 дугаар тогтоолын 2 дугаар хавсралт

**ХҮНИЙ ХӨГЖИЛ, НИЙГМИЙН БОДЛОГЫН БАЙНГЫН ХОРООНЫ ЭРХЛЭХ
АСУУДАЛД ХАМААРАХ ЦААШИД ХЭРЭГЖИЛТЭД НЬ ХЯНАЛТ ТАВИХ
ШААРДЛАГАТАЙ ХУУЛЬ, УЛСЫН ИХ ХУРЛЫН БОЛОН БАЙНГЫН ХОРООНЫ
ТОГТООЛЫН ЖАГСААЛТ**

ТҮС 3761 9023051390 9067184

Нэг. Монгол Улсын хуулиар үүрэг, чиглэл болгосон заалт

№	Хуулийн нэр, огноо, дугаар	Заалтын дугаар	Заалт	Хариуцах байгууллага
1.	Соёлын өвийг хамгаалах тухай /шинэчилсэн найруулга/ 2014.05.15	9.1	Нийтийн өмчийн соёлын биет өвд үнэлгээ тогтоох журмыг санхүү, төсвийн болон соёлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хамтран батална.	СС, ССАЖЗС
		14.1.12.	соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын дэргэд ажиллах палеонтологийн, археологийн, соёлын биет бус өвийн, түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийн, соёлын биет өвийг сэргээн засварлах мэргэжлийн зөвлөлийн бүрэлдэхүүн, ажиллах журмыг батлах;	ССАЖЗС
		35.1	Соёлын биет өвийг түрээслэх, худалдах, худалдан авах, түр солилцох журмыг соёлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.	ССАЖЗС
		37.6.	Аймаг, нийслэлийн Засаг дарга хот, суурин газарт орших түүхэн дурсгалт барилга, архитектурын дурсгалын харагдах сүр барааг хадгалах зорилгоор түүний эргэн тойронд шинээр барих барилга байгууламжид өндрийн хязгаар тогтооно. Өндрийн хязгаар тогтоох шалгуур үзүүлэлтийг хот байгуулалтын болон соёлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд хамтран батална.	ССАЖЗС, ХББОСС
		47.2	Соёлын биет өвийг сэргээн засварлах журмыг соёлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн, түүхэн дурсгалт барилга, архитектурын дурсгалыг сэргээн засварлах журмыг соёлын болон барилгын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хамтран батална.	ССАЖЗС, ХББОСС
2.	Номын сангийн тухай 2014.12.19	13.1	Цахим уншлагын үйлчилгээ үзүүлэх журмыг соёлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.	ССАЖЗС
3.	Биеийн тамир, спортын тухай /шинэчилсэн найруулга/ 2024.06.05	9.1.5.	9.1.Засгийн газар биеийн тамир, спортын талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ: олимп тив, дэлхийн наадам болон дэлхийн аварга шалгаруулах тэмцээн, үндэсний хэмжээний тэмцээн, наадамд амжилттай оролцож, медаль хүртсэн тамирчин, дасгалжуулагчид мөнгөн шагнал олгох, урамшуулах журам батлах;	ССАЖЗС
		10.1.2.	10.1.Биеийн тамир, спортын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ. өсвөр үе, хүүхдийн нас, биеийн онцлогт тохирсон	ССАЖЗС

			шинжлэх ухааны үндэслэлтэй сургалт явуулах, тэмцээн уралдаан зохион байгуулах журам батлах	
		10.1.7.	орон нутгийн биеийн тамир, спортын байгууллага биеийн тамир, спортын хууль тогтоомжид нийцүүлэн нэмэлт болон төлбөртэй үйлчилгээ үзүүлэх тариф, орлогыг зарцуулах үлгэрчилсэн журмыг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнтэй хамтран батлах;	ССАЖЗС, СС
		10.1.8.	спортын тэмцээн, наадмын норматив, шаардлага, нээлт, хаалтын дэг, соёл, удирдлага, зохион байгуулах журам батлах;	ССАЖЗС
		22.4.	Спортын холбоо, клубийг магадлан итгэмжлэх журам, шалгуур үзүүлэлт, үйлчилгээний төлбөрийн дэмжлэг үзүүлэх хэмжээг биеийн тамир, спортын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.	ССАЖЗС
		32.1.	Спортын дасгалжуулагч, арга зүйчид мэргэжлийн зэрэг олгох журмыг биеийн тамир, спортын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.	ССАЖЗС
		37.7.	Спортын цахим мэдээллийн сан бүрдүүлэх, хадгалах, хамгаалах, ашиглах, түгээх журмыг спортын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.	ССАЖЗС
4.	Музейн тухай 2021.01.29	7.4	Энэ хуулийн 7.3-т заасан үнэлгээ хийх аргачлал, үнэлгээ хийх этгээдэд тавих шалгуурыг соёлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.	ССАЖЗС
		9.4	Төрөөс энэ хуулийн 9.1-д заасан үйлчилгээ үзүүлсэнтэй холбогдох зардлыг хувийн музейд нөхөн олгох бөгөөд холбогдох журмыг Засгийн газар батална.	Засгийн газар (ССАЖЗЯ)
5.	Кино урлагийг дэмжих тухай 2021.07.02	14.3.	Кино зураг авах зориулалттай төрийн өмчийн барилга байгууламж, шаардлагатай тоног төхөөрөмжийг монгол болон хамтарсан кино бүтээхэд хөнгөлөлттэй нөхцөлөөр ашиглуулна. Хөнгөлөлттэй нөхцөлөөр ашиглуулах журмыг соёл, боловсрол болон санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд хамтран батална.	ССАЖЗС, БС, СС
6.	Соёлын тухай 2021.07.02	7.6.	Соёлын байгууллагыг үйл ажиллагааны чадавх, нөхцөлийг нь харгалзан Үндэсний соёлын байгууллагаар тогтооно. Үндэсний соёлын байгууллагад тооцох шалгуур үзүүлэлт, холбогдох журмыг Засгийн газар батална.	Засгийн газар (ССАЖЗЯ)
		8.2.	Нүүдлийн соёл иргэншлийн дурсгалт газарт уламжлалт ахуйг хамгаалах тааламжтай нөхцөлийг бүрдүүлж, хуульд зааснаас бусад дэглэмийг тогтоох, уламжлалт ахуй эрхлэгчдэд дэмжлэг үзүүлэх журмыг Засгийн газар батална.	Засгийн газар (ССАЖЗЯ)
		8.3.	Монголын ард түмний оюун санааны нэгдмэл байдлыг илэрхийлэх бэлгэ тэмдэг болсон түүхэн суут хүний алдар, дүр төрхийг эрхэмлэн, хүндэтгэлтэй хандаж, хамгаалах бөгөөд холбогдох журмыг Засгийн газар батална.	Засгийн газар (ССАЖЗЯ)

11.4.	Соёлын боловсрол олгоход дэмжлэг үзүүлэх арга хэмжээ, төлөвлөгөөг соёлын, боловсрол, шинжлэх ухааны болон эдийн засаг, хөгжлийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд хамтран батлах бөгөөд уг арга хэмжээ, төлөвлөгөөнд дараах асуудлыг тусгана:	ССАЖЗС, БС, ЭЗХС
11.5.	Боловсролын сургалтын байгууллагад суралцагчийн заавал судлах уран бүтээлийн жагсаалт, түүнийг судлахтай холбогдсон журмыг боловсролын болон соёлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд хамтран батална.	ССАЖЗС, БС,
12.2.	Соёлын үнэт зүйлийн үндэсний бүртгэл, мэдээллийн нэгдсэн санг бүрдүүлэх, эрхлэн хөтлөх, ашиглах журмыг соёлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.	ССАЖЗС
18.5.	Төрийн болон орон нутгийн өмчийн соёлын байгууллага нь мэргэжлийн холбоод, иргэний төлөөллийг оролцуулсан олон нийтийн зөвлөлтэй байж болно. Олон нийтийн зөвлөлийн ажиллах үлгэрчилсэн журмыг соёлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.	ССАЖЗС
18.6	Төрийн болон орон нутгийн өмчийн соёл урлагийн байгууллага нь удирдлага, урын сангийн бодлогын болон засаглалын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх чиг үүрэг бүхий Удирдах зөвлөлтэй байна. Удирдах зөвлөлийн ажиллах журмыг Засгийн газар батална.	Засгийн газар (ССАЖЗЯ)
25.3.	Сум, дүүргийн соёлын төв, соёлын ордны үйл ажиллагааны жишиг дүрмийг соёлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.	ССАЖЗС
26.4.	Соёлын салбарын зарим ажил, үйлчилгээг мэргэжлийн төрийн бус болон хувийн хэвшлийн байгууллагаар гүйцэтгүүлж болох бөгөөд уг байгууллагад тавих нийтлэг шаардлага, шалгуур үзүүлэлт болон холбогдох журмыг соёлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.	ССАЖЗС
30.5	Энэ хуулийн 30.4-т заасан барилга байгууламж, хөшөө, урлагийн бүтээлийн жагсаалтыг Засаг даргын санал, эрдэм шинжилгээний байгууллагын дүгнэлтийг үндэслэн соёлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.	ССАЖЗС
32.9.	Соёлын ажилтныг олон улсын хэмжээний соёл, урлагийн наадам, уралдаан тэмцээнд оролцоход төрөөс дэмжлэг үзүүлж, онцгой амжилт гаргасан соёлын ажилтанд мөнгөн шагнал олгох бөгөөд холбогдох журмыг Засгийн газар батална.	Засгийн газар (ССАЖЗЯ)
33.3.	Соёлын ажилтанд мэргэшлийн зэрэг, мэргэшлийн зэргийн нэмэгдэл олгох бөгөөд холбогдох журмыг Засгийн газар батална.	Засгийн газар (ССАЖЗЯ)
36.3.	Төрийн болон орон нутгийн өмчийн соёлын байгууллага нь хүүхэд, өндөр настан, хугацаат цэргийн алба хаагч, хөгжлийн	ССАЖЗС

			бэрхшээлтэй хүний соёлын үйл ажиллагаанд оролцох сонирхлыг нь дэмжих бөгөөд төлбөрийн хөнгөлөлт үзүүлэх журмыг соёлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.	
		37.6.	Сум, дүүргийн соёлын төв, соёлын ордны үйл ажиллагааг үнэлэх аргачлалыг соёлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.	ССАЖЗС
7.	Ерөнхий боловсролын сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний тухай 2019.05.30	10.1	Сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний талаар Монгол Улсын Засгийн газар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ: 10.1.1.сургуулийн нэг хүүхдэд ногдох хоолны зардлын нормативыг инфляцийн түвшин болон суралцагчийн шим тэжээлийн хэрэгцээг харгалзан жил тутам шинэчлэн батлах;	Засгийн газар (БЯ)
8.	Боловсролын ерөнхий хууль /Шинэчилсэн найруулга/ 2023.07.07	23.5.	Энэ хуулийн 23.3-т заасан Мэргэжлийн зөвлөлийн бүрэлдэхүүн, ажиллах журмыг боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.	БС
		26.1.8.	хуульд өөрөөр заагаагүй бол мэргэжлийн болон техникийн, дээд боловсролын сургалтын байгууллага болон хөтөлбөрийг магадлан итгэмжлэх, магадлан итгэмжлэл хийх журам болон шинжээчид тавих шаардлага батлах;	БС, ГБХНХС
		26.1.11.	зайн болон цахим сургалт зохион байгуулах, эзэмшсэн боловсролыг үнэлэх, дүйцүүлэх журам батлах;	БС, ГБХНХС
		26.1.23.	боловсролын чанарын баталгаажуулалт хийх журам, аргачлал батлах;	БС, ГБХНХС
		37.6.	Боловсролын сургалтын байгууллага сургууль хөгжүүлэх сантай байж болох бөгөөд сангийн үйл ажиллагааны үлгэрчилсэн журмыг боловсролын болон санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хамтран батална.	БС, СС
		38.10.	Энэ хуулийн 38.5.1-д заасан зардлыг үндэсний хөтөлбөр хэрэгжүүлж байгаа төрийн бус өмчийн ерөнхий боловсролын сургуульд гэрээний гүйцэтгэлд үндэслэн олгох бөгөөд гэрээний үр дүнгийн шалгуурыг боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.	БС
		39.2.	Энэ хуулийн 39.1-д заасан орчны норм, нормативыг холбогдох хууль тогтоомж, боловсролын стандартыг үндэслэн боловсролын, эрүүл мэндийн болон санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд хамтран батална.	БС, ЭМС, СС
9.	Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай /Шинэчилсэн найруулга/ 2023.07.07	6.6.	Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуульд суралцаж байгаа ялгаатай хэрэгцээтэй суралцагчид хөгжлийн цогц дэмжлэг үзүүлэх журмыг боловсролын, нийгмийн хамгааллын болон эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд хамтран батална.	БС, ГБХНХС, ЭМС
		21.3.	Энэ хуулийн 21.1.1, 21.1.2-т заасан сургалт зохион байгуулах журмыг боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн	БС

			батална.	
		22.7.	Эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн хүсэлтээр бага боловсролыг гэрийн сургалтаар эзэмшүүлж болох бөгөөд гэрийн сургалт зохион байгуулах, түүнд хяналт тавих журмыг боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.	БС
		27.7.	Боловсролын болон суралцагчийн үнэлгээний журмыг боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.	БС
10.	Дээд боловсролын тухай /Шинэчилсэн найруулга/ 2023.07.07	12.10.	Энэ хуулийн 12.2-т заасан хөндлөнгийн үнэлгээ зохион байгуулах журмыг боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.	БС
		32.8.	Энэ хуулийн 32.2-т заасан зардлыг санхүүжүүлэх журмыг Засгийн газар батална.	Засгийн газар (БЯ)
11.	Мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын тухай /Шинэчилсэн найруулга/ 2023.07.07	11.2.	Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын үйл ажиллагаанд тавих шаардлага, сургалт зохион байгуулах журмыг боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.	БС
		12.5.	Энэ хуулийн 12.4-т заасан зээл олгох журмыг Засгийн газар батална.	Засгийн газар (БЯ)
		23.1.2.	мэргэжлийн өөрийн өртөг тооцох аргачлалыг санхүү, төсвийн болон боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд хамтран батлах.	СС, БС
12.	Шинжлэх ухаан, технологийн тухай 2024.05.15	10.1.6.а.	шинжлэх ухаан, технологийн салбарт мөрдөх дараах дүрэм, журмыг хууль тогтоомжид нийцүүлэн батлах: төрийн өмчит эрдэм шинжилгээний байгууллагын үндсэн чиглэлийг санхүүжүүлэх журам;	Засгийн газар (ЭЗХЯ)
		10.1.6.б.	шинжлэх ухаан, технологийг хөгжүүлэх тэргүүлэх чиглэл, цөм технологийг тодорхойлох журам;	Засгийн газар (ЭЗХЯ)
		10.1.6.в.	шинжлэх ухаан, технологийн үйлдвэрлэлийн нэгдлийн үлгэрчилсэн дүрэм;	Засгийн газар (ЭЗХЯ)
		10.1.6.г.	эрдэм шинжилгээний байгууллагын дэргэд гарааны компани байгуулах журам;	Засгийн газар (ЭЗХЯ)
		10.1.6.д.	төсвийн хөрөнгөөр гүйцэтгэсэн эрдэм шинжилгээ, туршилт, зохион бүтээх ажлын үр дүнд бий болсон оюуны өмчийг өмчлүүлэх, ашиглуулах журам;	Засгийн газар (ЭЗХЯ)
		10.1.6.е.	шинжлэх ухаан, технологийн салбарын шагнал олгох, шагналын хэмжээг тогтоох журам;	Засгийн газар (ЭЗХЯ)
		15.1.21.	15.1.Шинжлэх ухаан, технологийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага дараах эрх, үүргийг хэрэгжүүлнэ: шинжлэх ухааны докторын зэрэг хамгаалах, олгох журмыг батлах;	Засгийн газар (ЭЗХЯ)
		15.1.25.	төсвийн санхүүжилтээр гүйцэтгэсэн судалгаа хөгжүүлэлтийн ажлын үр дүнд бий болсон оюуны өмчид хамаарах бүтээгдэхүүнийг хууль, гэрээнд заасны дагуу хүн, хуулийн этгээдэд ашиглуулсны төлбөр авах журмыг батлах;	Засгийн газар (ЭЗХЯ)
		15.1.26.	шинжлэх ухаан, технологийн салбарын	Засгийн

			мэдээллийн нэгдсэн сан ажиллуулах журмыг батлах;	газар (ЭЗХЯ)
		15.1.27.	шинжлэх ухаан, технологийн төслийн өртөг, зардлыг тодорхойлох, түүний зарцуулалтад санхүүгийн хяналт тавих журмыг батлах;	Засгийн газар (ЭЗХЯ)
		15.1.28.	шинжлэх ухаан, технологийн төсөлд шинжээчийг сонгон ажиллуулах, үнэлгээ өгөх журмыг батлах;	Засгийн газар (ЭЗХЯ)
		15.1.29.	залуу судлаач, эрдэмтэнд судалгааны грант олгох журмыг батлах;	Засгийн газар (ЭЗХЯ)
		23.2.	Энэ хуулийн 23.1-д заасан судалгааны үндсэн чиглэлээр санхүүжилтийн дэмжлэг олгох журмыг Засгийн газар батална.	Засгийн газар (ЭЗХЯ)
		28.4.	Судалгааны ажлын арга барил эзэмшсэн байдал, ур чадварын түвшин, ажлын үр дүнг үнэлэх, зэрэг дэвийг тогтоох зорилгоор эрдэм шинжилгээний ажилтныг 4 жил тутамд аттестатчилалд хамруулах бөгөөд холбогдох журмыг шинжлэх ухаан, технологийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.	ЭЗХС
		28.8.	Улсын төсвөөс санхүүждэг эрдэм шинжилгээний байгууллагын ажилтны цалингийн сүлжээ, тэдгээрт нэмэгдэл, нэмэгдэл хөлс олгох журмыг Засгийн газар батална.	Засгийн газар (ЭЗХЯ)
13.	Соёлын бүтээлч үйлдвэрлэлийг дэмжих тухай 2024.05.16	8.4.	Энэ хуулийн 8.1, 8.2-т заасан үндэсний соёлын агуулгыг дэмжих, соёлын бүтээгдэхүүн, үйлчилгээ худалдан авах эрхийн бичиг олгох, хянах, хэрэглэгчийн статистик мэдээлэлд үндэслэн хязгаарлалт тогтоохтой холбоотой журам болон эрхийн бичгийн санхүүжилтийн хэмжээг Засгийн газар батална.	Засгийн газар (ССАЖЗЯ)
		9.5.	Энэ хуулийн 9.4-т заасан арга хэмжээг хэрэгжүүлэх журмыг Засгийн газар батална. /9.4.Соёлын бүтээлч үйлдвэрлэл эрхлэгчийн эрэлттэй мэргэжлийн чиглэлээр мэргэжилтэн бэлтгэх, мэргэшүүлэхэд гарсан зардлыг бүрэн болон хэсэгчлэн олгоно./	Засгийн газар (ССАЖЗЯ)
		11.2.	Энэ хуулийн 10.1, 11.1-д заасан судалгаа, хөгжүүлэлтийн шалгуур тогтоох аргачлал, зарцуулсан зардлын тодорхой хувийг буцаан олгох болон судалгааны байгууллагын үйл ажиллагааны журмыг Засгийн газар батална	Засгийн газар (ССАЖЗЯ)
		12.4.	Энэ хуулийн 12.2, 12.3-т заасан тодорхой нөхцөл, системийн мэдээллийг бүрдүүлэх этгээдэд тавих шалгуур, дэмжлэг үзүүлэх журмыг Засгийн газар батална.	Засгийн газар (ССАЖЗЯ)
		14.2.	Энэ хуулийн 14.1, 14.5-д заасан арга хэмжээний жагсаалт, дэмжлэг үзүүлэх журмыг Засгийн газар батална.	Засгийн газар (ССАЖЗЯ)
		14.4.	Соёлын бүтээлч үйлдвэрлэлийн бүртгэл, мэдээллийн санг цахим хэлбэрт оруулах, мэдээллийн сан үүсгэх, мэдээллийн төрлийг тодорхойлох, ашиглах, төрийн байгууллага хооронд мэдээлэл солилцох, түүний байнгын тасралтгүй үйл ажиллагаа, хадгалалт, хамгаалалт, нууцлалын	ССАЖЗЯ, ЦХИХХЯ, ХЗДХЯ

			найдвартай байдлыг хангах журмыг соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага цахим хөгжил, харилцаа холбооны болон хууль зүй, дотоод хэргийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай хамтран батална.	
		15.7.	Энэ хуулийн 15.4-т заасны дагуу ашиглах журам болон 15.6-д заасан хөнгөлөлт үзүүлэх нөхцөл, журмыг соёлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.	ССАЖЗС
		17.8.	Энэ хуулийн 17.3, 17.4, 17.5, 17.6, 17.7-д заасан асуудлаар төсөл сонгон шалгаруулалт зарлах болон төслийн саналыг дүгнэсний үндсэн дээр санхүүжүүлэх, нэгдсэн бодлогоор хангах арга хэмжээг Засгийн газар, соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, бүх шатны Засаг дарга хэрэгжүүлэх бөгөөд холбогдох журмыг Засгийн газар батална.	Засгийн газар (ССАЖЗЯ)
		19.2.	Соёлын бүтээлч үйлдвэрлэл эрхлэгчийг соёлын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага бүртгэж, тодорхойлолт олгох бөгөөд соёлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн холбогдох журмыг батална.	ССАЖЗС
14.	Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай 2016.02.05	12.2	Монгол дохионы хэлний хэлмэрч, орчуулгын үйл ажиллагаа эрхлэх, үйлчилгээ үзүүлэх журмыг боловсролын болон хөгжлийн бэрхшээлтэй хүний асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хамтран батална.	БЯ, ГБХНХЯ
		15.8	Энэ хуулийн 15.6-д заасан сургалтын зардлын хэмжээ, олгох журмыг Засгийн газар батална.	Засгийн газар (ГБХНХЯ)
15.	Эмнэлгийн тусламж, үйлчилгээний тухай 2016.04.22	21.6	Хувийн хэвшлийн төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, нэгдсэн эмнэлэг, клиник, түргэн тусламжийн төвөөр гэрээний үндсэн дээр гүйцэтгүүлэх энэ хуулийн 18.1-д заасан улсын төсвөөс санхүүжүүлэх тусламж, үйлчилгээний жагсаалт, сонгон шалгаруулах болон гэрээ байгуулах, хэрэгжилтийг дүгнэх, хяналт тавих, гэрээг сунгах, дуусгавар болгох журам, гэрээний загвар, гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлтийг Засгийн газар батална.	Засгийн газар (ЭМЯ)
16.	Нялх, балчир хүүхдийн хүнсний тухай 2017.05.12	15.3	Эхийн сүүний нөөцийн банк байгуулж, ажиллуулах журмыг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.	ЭМС
17.	Донорын тухай /Шинэчилсэн найруулга/ 2018.01.19	20.3	Донорын цус, цусан бүтээгдэхүүн, сорьц, эд, эрхтнийг улсын хилээр нэвтрүүлэх журмыг Засгийн газар батална.	Засгийн газар (ЭМЯ)
		11.3	Донорын цус, цусан бүтээгдэхүүн болон донорын эс, эд, эрхтнийг шилжүүлэн суулгах тусламж, үйлчилгээний үнийн жишгийг эрүүл мэндийн болон санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд хамтран батална.	ЭМС, СС
		7.1.7.	Цусны болон эс, эд, эрхтний донорын нэгдсэн бүртгэл, мэдээллийн сан	ЭМС

			байгуулах, сангийн ажиллах журмыг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батлах;	
18.	Эрүүл мэндийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай 2020.05.15	8.5.	Энэ хуулийн 8.1.24, 19.3.3-т заасан үйл ажиллагааг зохион байгуулах журмыг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.	ЭМС
		8.6.	Эрүүл мэндийн нэн шаардлагатай тусламж, үйлчилгээний багцыг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.	ЭМС
		8.7.	Эмнэлгийн урт хугацааны тусламж, үйлчилгээг боловсрол, нийгмийн халамжийн үйлчилгээтэй хослуулан үзүүлэх журам, жагсаалтыг эрүүл мэндийн, боловсролын болон нийгмийн халамжийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хамтран батална.	ЭМС, ГБХНХС
		8.9.	Хүний амь насанд аюултай, хөгжлийн бэрхшээлд хүргэдэг ховор тохиолдох өвчин, эмгэгийг тодорхойлох аргачлалыг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.	ЭМС
		24.2	Энэ хуулийн 24.6.3, 24.6.4-т заасан эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний багц, тоо хэмжээ, чанарын шалгуур үзүүлэлт, төлбөрийн хэмжээ, санхүүжүүлэх болон хяналт тавих журмыг холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн эрүүл мэндийн болон санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хамтран батална.	ЭМС, СС
		41.3.	Ахуйн шавж, мэрэгч устгах, ариутгах, халдваргүйжүүлэх бодисыг бүртгэх үйл ажиллагаатай холбоотой хэрэгцээний үнэлгээ хийх, мэргэжлийн үйл ажиллагааны төслийг үнэлэх болон хэрэгцээний тодорхойлолт гаргах шинжээч сонгон шалгаруулах, томилох, шинжээчийн ажиллах журмыг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн, хэрэгцээний тодорхойлолт олгохтой холбоотой үйлчилгээний төлбөрийн хэмжээ, холбогдох зардлын жишиг, шинжээчид олгох зардлын жишгийг эрүүл мэндийн болон санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хамтран батална.	ЭМС, СС
		25.15.	Эмнэлгийн мэргэжилтний мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгох үйл ажиллагааны удирдлага зохион байгуулалт, зөвшөөрөлтэй холбоотой үйл ажиллагааг нэгдсэн удирдлагаар хангах, арга зүйн дэмжлэг үзүүлэх орон тооны бус зөвлөлийн бүрэлдэхүүн, ажиллах журам, зөвшөөрлийн шалгалт зохион байгуулах, багц цаг тооцох, зөвшөөрлийн гэрчилгээ олгох, нөхөн олгох журам, бүрдүүлэх баримт бичиг, мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийн гэрчилгээний загвар, холбогдох маягтыг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн, холбогдох зардлын жишгийг санхүү,	ЭМС, СС

			төсвийн болон эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хамтран батална.	
19.	Хөдөлмөрийн тухай 2021.07.02	17.3.	Мэргэшлийн үндэсний хүрээг бүрдүүлэх, зохицуулах журмыг хөдөлмөрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, ажил олгогчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг төлөөлөн хамгаалах байгууллага болон мэргэжлийн холбоодын саналыг үндэслэн Засгийн газар батална.	Засгийн газар (ГБХНХЯ)
		17.4.	Хүний мэргэшлийн түвшнийг үнэлэх, хүлээн зөвшөөрөх, баталгаажуулах журмыг хөдөлмөрийн болон боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд хамтран батална.	Засгийн газар (БЯ, ГБХНХЯ)
		17.7.	Ажил мэргэжлийн үндэсний ангилал, тодорхойлолтыг ажил олгогчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг төлөөлөн хамгаалах байгууллага болон мэргэжлийн холбоодын саналыг үндэслэн тухайн салбарын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага боловсруулж, хөдөлмөрийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.	ГБХНХЯ
		62.5.	Нарийн мэргэжлээр дагалднаар ажиллах журам, мэргэжлийн жагсаалтыг Үндэсний хорооны саналыг үндэслэн хөдөлмөрийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.	ГБХНХС
		103.1.2	ажилтны мэргэшлийн зэрэг тогтоох, олгох, баталгаажуулах нийтлэг журам.	ГБХНХС
20.	Ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний тухай 2021.12.24	9.9.	Хөдөлмөрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага цахим систем ашиглан тусгай зөвшөөрөлтэй холбоотой үйлчилгээг цахимаар үзүүлж болно. Цахим системээр зөвшөөрлийн үйлчилгээ үзүүлэх, цахим системийг ашиглах журмыг хөдөлмөрийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.	ГБХНХС
		23.10.	Хөдөлмөр эрхлэлтийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага цахим систем ашиглан гадаадын иргэнийг хөдөлмөр эрхлэхэд урих зөвшөөрөл, гадаад ажилтныг Монгол Улсад хөдөлмөр эрхлүүлэх зөвшөөрөлтэй холбоотой үйлчилгээг цахимаар үзүүлж болно. Цахим системээр зөвшөөрлийн үйлчилгээ үзүүлэх, цахим системийг ашиглах журмыг хөдөлмөрийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.	ГБХНХС
		33.5.	Мэдээллийн сангийн бүрдэл, уг санг бүрдүүлэх, нууцлал, ашиглалт, хадгалалт, хамгаалалт, аюулгүй байдал, байгууллага хооронд мэдээлэл солилцохтой холбоотой журмыг Засгийн газар тогтооно.	Засгийн газар (ГБХНХЯ)
21.	Нийгмийн даатгалын ерөнхий хууль /Шинэчилсэн найруулга/ 2023.07.07	35.15.	Үндэсний зөвлөлийн дүрэм болон энэ хуулийн 35.3-т заасан нээлттэй сонгон шалгаруулах журмыг Улсын Их Хурлын холбогдох Байнгын хороо батална.	ХХНББХ
		38.9.	Энэ хуулийн 38.2-т заасан хяналт шалгалт хийх журмыг нийгмийн даатгалын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага	ГБХНХС

			батална.	
22.	Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн тухай /Шинэчилсэн найруулга/ 2023.07.07	13.3.	Ажил олгогчид шимтгэлийн хөнгөлөлт үзүүлэхтэй холбогдсон журмыг Нийгмийн даатгалын үндэсний зөвлөл батална.	НДҮЗ
23.	Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний тухай 2024.01.12	6.2.	Энэ хуулийн 6.1-д заасан Зөвлөлийн шийдвэр нь дүгнэлт, зөвлөмж хэлбэртэй байх бөгөөд Зөвлөлийн бүрэлдэхүүн, ажиллах журмыг Ерөнхий сайдын санал болгосноор Засгийн газар батална.	Засгийн газар (ЭМЯ)
		7.1.1.	7.1.Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн нь нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ: нийгмийн эрүүл мэндийн мэдээллийн сангийн ажиллах журмыг цахим хөгжил, харилцаа холбооны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнтэй хамтран батлах;	ЭМС
		7.1.2.	нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын үед тохиолдлын удирдлагын тогтолцоогоор ажиллах журмыг гамшгийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнтэй хамтран батлах.	ЭМС, ШС
		15.3.	Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд олон нийтийн оролцоог хангах, сайн дурын ажилтныг урамшуулах журмыг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.	ЭМС
		19.5.	Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний багц, төлбөрийн хэмжээ, санхүүжүүлэх, төлбөртэй тусламж, үйлчилгээний төрөл, орлого, хандив тусламжийг зарцуулах журмыг эрүүл мэндийн болон санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хамтран батална.	ЭМС, СС
24.	Хүүхэд хамгааллын тухай 2024.01.17	14.6.	Хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хүүхдийн эрх, хүүхэд хамгааллын чиглэлээр хэвлэл мэдээллийн хэрэгсэл, олон нийттэй харилцах, соён гэгээрүүлэх чиглэлийн стратегийг боловсруулж батална.	ГБХНХЯ
		18.8.	Нөхцөл байдлын үнэлгээ хийх журмыг хүүхэд, гэр бүлийн хөгжлийн болон хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд хамтран батална.	ГБХНХС, ХЗДХС
		23.8.	Боловсролын сургалтын байгууллага, сүм хийдийн орчны аюулгүй байдалд нөхцөл байдлын үнэлгээ хийх журмыг хүүхэд, гэр бүлийн хөгжлийн болон боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд хамтран батална.	ГБХНХС, БС
		23.9.	Боловсролын орчин дахь хүүхэд хамгааллын үйлчилгээний нийтлэг шаардлагыг хүүхэд, гэр бүлийн хөгжлийн болон боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд хамтран батална.	ГБХНХС, БС
		25.13.	Энэ хуулийн 25.12-т заасан орон тооны бус зөвлөлийн бүрэлдэхүүн, ажиллах журмыг	Засгийн газар

			Засгийн газар батална.	(ГБХНХЯ)
		27.8.	Соёл, спортын үйл ажиллагаанд хүүхдийг оролцуулах, хүүхдийн эрхийг хамгаалах журмыг соёлын, биеийн тамир, спортын болон хүүхэд, гэр бүлийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага хамтран баталж, мөрдүүлнэ.	ССАЖЗЯ, ГБХНХЯ
		29.6.	Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаан дахь хүүхэд хамгааллын журмыг хүүхэд, гэр бүлийн хөгжлийн болон хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд, Улсын ерөнхий прокурор, Шүүхийн ерөнхий зөвлөлийн дарга хамтран батална.	ГБХНХС, УЕП, ШЕЗ
		34.1.16	34.1.Хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага хүүхэд хамгааллын асуудлаар дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ: хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлэх ажилтныг давтан сургах, мэргэшүүлэх хөтөлбөр, журмыг батлах	ГБХНХЯ
25.	Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай 2024.06.05	23.10.	Эмийн эмнэлзүйн туршилтын үе шат, тавигдах шаардлага, оролцогч талуудын эрх, үүрэг, хариуцлага, гэрээний загвар, хяналт тавих журам, лабораторийн оношилгооны хэрэгслийн туршилт судалгаа хийх журмыг эрүүл мэндийн асуудал хариуцсан Засгийн газрын гишүүн батална.	ЭМС
		31.1.	Зайлшгүй шаардлагатай эм, эмнэлгийн хэрэгслийн жагсаалтыг эм, эмнэлгийн хэрэгслийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын саналыг үндэслэн эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хоёр жил тутамд шинэчлэн батална.	ЭМС
		47.6.	Гадаад улсын үйлдвэрлэгчээс, эсхүл олон улсын байгууллага, эмийн зохицуулалтын үнэлгээгээр Дэлхийн эрүүл мэндийн байгууллагаас хүлээн зөвшөөрөгдсөн эмийн зохицуулалтын эрх бүхий байгууллагатай гадаад улсаас шууд болон дамжуулан худалдан авах эм, эмнэлгийн хэрэглэгдэхүүн, биобэлдмэл, вакцины санхүүжилтийг зохицуулах журмыг эрүүл мэндийн болон санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд хамтран батална.	ЭМС, СС
		47.8.	Энэ хуулийн 47.7-д заасан саналыг үндэслэн зайлшгүй шаардлагатай эм, эмнэлгийн хэрэгслийн бөөний болон жижиглэнгийн үнийн нэмэгдэх хувь хэмжээний дээд хязгаарыг эрүүл мэндийн болон санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд хамтран батална.	ЭМС, СС
		47.9.	Эм, эмнэлгийн хэрэгслийн үнийг гадаад, дотоодын жишиг үнэ, үнийн ил тод байдлыг хангах, хэлцэл хийх, эрүүл мэндийн технологийн үнэлгээний арга ашиглах журмыг эрүүл мэндийн болон санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд хамтран батална.	ЭМС, СС
		47.16.	Эм, эмнэлгийн хэрэгслийн үнийн цахим	Засгийн

			мэдээллийн нэгдсэн санг ажиллуулах журмыг Засгийн газар батална.	газар (ЭМЯ)
		50.2.	Бүртгэлгүй, хуурамч эм, стандартын бус эм, чанар, аюулгүй байдал нь хангагдаагүй эмнэлгийн хэрэгсэл, эрүүл мэндийн нэмэлт бүтээгдэхүүний эргэлтээс сэргийлэх, илрүүлэх, шуурхай сэрэмжлүүлэх, эргүүлэн татах, устгах үйл ажиллагааг зохицуулах журмыг эм, эмнэлгийн хэрэгслийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын дарга батална.	ЭМС
		58.2.	Энэ хуулийн 50.1.4, 50.1.5, 50.1.6, 50.1.7, 50.1.8, 50.1.9, 50.1.10, 50.1.11, 50.1.15-д заасан бүрэн эрхийг хэрэгжүүлэхтэй холбоотой төлбөр, хураамжийн хэмжээ, зардлын жишиг, зарцуулах журмыг эрүүл мэндийн болон санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд хамтран батална.	ГБХНХС, СС
26.	Хүүхдийн эрхийн тухай хуульд нэмэлт оруулах тухай 2021.04.08	6.6	Хүүхдийн хөгжлийг дэмжих үйлчилгээг санхүүжүүлэх аргачлал, үйлчилгээний зардлын нормативыг хүүхэд, гэр бүлийн хөгжлийн, боловсролын болон санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд хамтран батална.	ГБХНХС, СС

Хоёр. Улсын Их Хурлын тогтоолоор үүрэг, чиглэл болгосон заалт

№	Тогтоолын нэр, огноо, дугаар	Заалтын дугаар	Заалт	Хариуцах байгууллага
1	Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай 2017.06.09 №46	1.9	Хөгжлийн бэрхшээлийг тогтоох олон улсын ангиллыг нэвтрүүлэх, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд ээлтэй, хүртээмжтэй орчныг бүрдүүлж, нийгмийн бүхий л үйлчилгээнд хамруулах.	Засгийн газар (ГБХНХЯ)
		1.12	Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн мэдээллийн нэгдсэн сан байгуулах.	Засгийн газар (ГБХНХЯ)
		1.13	Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан дэд бүтэц, тэдгээрийн мэдээллийн хүртээмжийг сайжруулах чиглэлээр эрх зүйн орчныг боловсронгуй болгох.	Засгийн газар (ГБХНХЯ)
2	Хууль хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай 2019.05.30 №53 /Ерөнхий боловсролын сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний тухай хууль/	1.2/	Ерөнхий боловсролын сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний тухай хуулийн 5.1.1-д заасны дагуу өдрийн хоолны үйлчилгээнд бага ангийн суралцагчдыг 2021-2022 оны хичээлийн жилээс эхлэн, дунд болон ахлах ангийн суралцагчдыг зохих бэлтгэл хангасны үндсэн дээр үе шаттайгаар тус тус хамруулах;	Засгийн газар (БоЯ)
		1.4/	Ерөнхий боловсролын сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасан байрын засвар үйлчилгээ, тоног төхөөрөмжид шаардагдах зардлыг энэ тогтоолын 8 дахь дэд заалтад заасан төлөвлөгөөний дагуу тухайн жилийн төсвийн төсөлд тусган улсын төсвөөс санхүүжүүлэх;	Засгийн газар (БоЯ)
		1.5/	Ерөнхий боловсролын сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.1-д заасан зардлын нормативыг инфляцийн түвшин болон	Засгийн газар (БоЯ)

			суралцагчийн шим тэжээлийн хэрэгцээг харгалзан Монгол Улсын Засгийн газраас жил тутам шинэчлэн батлах;	
		1.6/	Ерөнхий боловсролын сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний тухай хуулийн 10.2.12-т заасан хандив, тусламжийг хүлээн авах ажлыг иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын санаачилгаар холбогдох хууль тогтоомжийн хүрээнд зохион байгуулах;	Засгийн газар (Боя)
		1.7/	Ерөнхий боловсролын сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.1-д заасны дагуу төрийн болон орон нутгийн өмчийн сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний зориулалттай байрын түрээсийн гэрээг харилцан тохиролцож дуусгавар болгох ажлыг энэ тогтоолын 8 дахь дэд заалтад заасан төлөвлөгөөний дагуу зохион байгуулах;	Засгийн газар (Боя)
3	Хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах арга хэмжээний тухай 2020.01.10 №04 /Иргэний тэтгэвэр барьцаалсан зээлийн төлбөрийг төрөөс нэг удаа төлөх тухай хууль/	1.1/	1.Иргэний тэтгэвэр барьцаалсан зээлийн төлбөрийг төрөөс нэг удаа төлөх тухай хууль баталсантай холбогдуулан дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газар /У.Хүрэлсүх/-т даалгасугай: 1/төрийн өмчит "Эрдэнэс Монгол" ХХК-ийн үйл ажиллагааг сайжруулах замаар орлогыг нэмэгдүүлэх арга хэмжээг авах, шаардлагатай тохиолдолд "Эрдэнэс силвер ресурс" ХХК-ийн аж ахуйн нэгжийн орлогын албан татварын хөнгөлөлт, чөлөөлөлтийн асуудлыг судалж, саналаа холбогдох хууль тогтоомжийн өөрчлөлтийн хамт Монгол Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх;	Засгийн газар
4	Хууль баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай 2021.06.24 №54 /Кино урлагийг дэмжих тухай хууль/	1	Кино урлагийг дэмжих тухай хуульд заасан кино үйлдвэрлэл эрхлэхэд татварын чөлөөлөлт, хөнгөлөлт үзүүлэхтэй холбоотойгоор Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслүүдийг 2021 оны намрын ээлжит чуулган эхлэхээс өмнө Монгол Улсын Их Хуралд өргөн мэдүүлж, Кино урлагийг дэмжих тухай хууль хүчин төгөлдөр болох хугацаанаас өмнө батлуулахыг Монгол Улсын Засгийн газар /Л.Оюун-Эрдэнэ/-т даалгасугай.	Засгийн газар (ССАЖЗЯ)
5	Хууль батлагдсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай 2021.07.02 №57 /Хөдөлмөрийн тухай хууль /Шинэчилсэн найруулга//	1.1/	1.Хөдөлмөрийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийг баталсантай холбогдуулан дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газар /Л.Оюун-Эрдэнэ/-т даалгасугай: 1/Хөдөлмөрийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/-д нийцүүлэн Эрүүгийн хууль, Иргэний хууль, Зөрчлийн тухай хуульд өөрчлөлт оруулах саналыг боловсруулж, Улсын Их Хурлын 2021 оны намрын ээлжит чуулганы хугацаанд, Үйлдвэрчний эвлэлүүдийн эрхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг 2022 онд багтаан Улсын Их Хуралд тус тус өргөн мэдүүлэх;	Засгийн газар (ГБХНХЯ)
		1.2/	сум, дүүргийн хөдөлмөрийн эрхийн маргаан	Засгийн

			зохицуулах гурван талт хороог байгуулж, хорооны гишүүд, хөдөлмөрийн зуучлагч, арбитрчдыг бэлтгэх, чадавхжуулах ажлыг ажил олгогч, ажилтны эрх, хууль ёсны ашиг сонирхлыг төлөөлөн хамгаалах үндэсний байгууллагатай хамтран зохион байгуулах;	газар (ГБХНХЯ)
6	Монгол хүний удмын сангийн аюулгүй байдлыг хамгаалах, хүн амын өсөлтийг дэмжих талаар авах арга хэмжээний тухай 2022.01.14 №01	1.1/	1.Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогод туссан Монгол хүний удмын санг хамгаалж, эрсдэлээс урьдчилан сэргийлэх чадавхыг бэхжүүлэх, хүн амын өсөлтийг дэмжих зорилтын хэрэгжилтийг эрчимжүүлэх чиглэлээр дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газар /Л.Оюун-Эрдэнэ/-т даалгасугай: 1/монгол хүний удмын сангийн аюулгүй байдлыг хамгаалах, монгол хүн судлалын салбарыг сэргээн хөгжүүлэх асуудлыг холбогдох хөгжлийн зорилтот хөтөлбөрт бие даасан бүлэг болгон боловсруулж, Улсын Их Хуралд 2022 онд багтаан өргөн мэдүүлэх;	Засгийн газар (ЭЗХЯ)
		1.2/	монгол хүний удмын санг цус ойртолт, удамшлын өвчлөлөөс сэргийлэх зорилгоор "Угийн бичиг"-ийг айл өрх бүрд шинжлэх ухааны үндэслэлтэйгээр хөтлүүлэн хэвшүүлэх ажлыг орон даяар 2024 онд багтаан хэрэгжүүлэх, шаардлагатай бол холбогдох судалгаанд тулгуурлан ургийн овгийн нэршлийг шинэчлэх арга хэмжээг зохион байгуулах;	Засгийн газар (ССАЖЗЯ)
		1.3/	хүний генетикийн оношилгоо, эмчилгээ, генийн сангийн аюулгүй байдлыг зохицуулах чиглэлээр холбогдох хуулийн төслийг боловсруулж, Улсын Их Хуралд 2023 онд багтаан өргөн мэдүүлэх;	Засгийн газар (ЭМЯ)
		1.4/	монгол хүний удмын сангийн аюулгүй байдлыг хамгаалах чиглэлээр орчин үеийн дэвшилтэт технологи бүхий генетикийн лаборатори, генийн сан байгуулах асуудлыг судлан шийдвэрлэх, шаардагдах төсвийг улсын төсвөөс санхүүжүүлэх;	Засгийн газар (ЭМЯ)
		1.5/	монгол хүний удмын санг хамгаалах, эрсдэлээс урьдчилан сэргийлэх төрийн бодлогыг хэрэгжүүлэх удирдлага, зохион байгуулалтыг боловсронгуй болгох саналыг боловсруулж, Улсын Их Хуралд танилцуулах;	Засгийн газар
		1.6/	Монгол Улсын хүн ам, эдийн засаг, дэд бүтэц, хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, нийлүүлэлттэй уялдуулан хот, хөдөөгийн хөгжлийн тэнцвэрийг хангах, төвлөрлийг сааруулах асуудлыг хөгжлийн зорилтот хөтөлбөрт тусган хэрэгжүүлэх;	Засгийн газар (ЭЗХЯ, ГБХНХЯ)
		1.7/	хүн амын өсөлт, нөхөн үржихүй, гэр бүлийн тогтвортой байдлыг дэмжих зорилгоор жирэмсэн эмэгтэй, эх, хүүхдэд үзүүлэх эмнэлгийн тусламж, үйлчилгээ, асаргаа сувилгааны чанар, хүртээмжийг сайжруулах, хүүхдийн тооноос хамааруулан гэр бүлд дэмжлэг үзүүлэх талаар холбогдох хуулийн төслийг боловсруулж, Улсын Их Хуралд	Засгийн газар (ЭМЯ, ГБХНХЯ)

			өргөн мэдүүлэх.	
7	Хууль баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай 2023.07.07 №73 /Боловсролын ерөнхий хууль /Шинэчилсэн найруулга//	1.1/	1.Боловсролын ерөнхий хууль /Шинэчилсэн найруулга/-ийг баталсантай холбогдуулан дараах арга хэмжээг авахыг Монгол Улсын Засгийн газар /Л.Оюун-Эрдэнэ/-т даалгасугай: Боловсролын ерөнхий хууль /Шинэчилсэн найруулга/, Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хууль /Шинэчилсэн найруулга/, Мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын тухай хууль /Шинэчилсэн найруулга/, Дээд боловсролын тухай хууль /Шинэчилсэн найруулга/-д нийцүүлэн Зөвшөөрлийн тухай хуулийн 8.1 дүгээр зүйлийн 7.1, 7.2, 7.4, 7.9 дэх заалт, 8.2 дугаар зүйлийн 6.2, 6.3, 6.4, 6.5 дахь заалт, Зөрчлийн тухай хуулийн 9.1, 9.2, 9.3, 9.4, 9.11 дүгээр зүйлд өөрчлөлт оруулах хуулийн төслийг боловсруулан Монгол Улсын Их Хурлын 2023 оны намрын ээлжит чуулганы хугацаанд багтаан Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх;	Засгийн газар (БЯ)
		1.5/	бүх нийтийн англи хэлний суралцахуйг дэмжиж, бага, дунд боловсролын сургалтын тогтолцоонд олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн англи хэлний хөтөлбөр, цахим технологи, багш бэлтгэх арга зүйг нэвтрүүлж суралцагчдад суралцах тэгш боломж бүрдүүлэх цогц арга хэмжээг төлөвлөж, шаардагдах төсөв, хөрөнгийг жил бүрийн улсын төсвийн төсөлд тусган батлуулах.	Засгийн газар (БЯ)
8	Монгол Улсын Их Хурлын хянан шалгах түр хорооноос эмийн үнийн өсөлтийн шалтгаан, нөхцөлд хяналт шалгалт хийсэнтэй холбогдуулан авах арга хэмжээний тухай 2024.05.02 №38	1.1/в/	зайлшгүй шаардлагатай эмийн жагсаалтад орох эмийг сонгох шалгуурыг тодорхой болгож, зах зээлийн бодит үнэд тулгуурлан үнэлдэг болох, эмийн үнийг хянах, борлуулалтын үнийн дээд хязгаарын зохицуулалтыг нарийвчлан тусгах;	Засгийн газар (ЭМЯ)
		1.1/г/	Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газрын чиг үүргийг тодорхой болгон, эрх зүйн чадамжийг дээшлүүлж, байр, санхүүжилтийн асуудлыг цогцоор нь шийдвэрлэх;	Засгийн газар (ЭМЯ)
		1.2/	1.Эмийн үнийн өсөлтийн шалтгаан, нөхцөлийг тодорхойлох, Монгол Улсын эм зүйн салбарын бүртгэл, чанар, хяналт шалгалтын тогтолцоог сайжруулах хянан шалгах түр хорооны санал, дүгнэлтийн хүрээнд эм зүйн салбарын үйл ажиллагааг үр дүнтэй зохион байгуулах чиглэлээр дараах асуудалд анхаарал хандуулж, холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газар /Л.Оюун-Эрдэнэ/-т даалгасугай: 2/эм, эмнэлгийн хэрэгслийн чанар, аюулгүй байдал, хангамж, хүртээмжийг нэгдсэн цахим тогтолцоогоор хянах, зохицуулах зорилгоор Гаалийн ерөнхий газар, Татварын ерөнхий газар болон Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт зохицуулалтын газар зэрэг төрийн байгууллагуудын мэдээллийг нэгтгэх;	Засгийн газар (ЭМЯ)
		1.3/	эмийн үнийн өсөлтөд олон нийтээс тавих хяналтыг бий болгох зорилгоор нийлүүлэлт,	Засгийн газар (ЭМЯ)

	борлуулалтын үнийн мэдээллийг ижил нэгжээр цахим хэрэгслээр дамжуулан нээлттэй болгох;	
1.4/	LICEMED (druginfo.mohs.mn) системийн тоног төхөөрөмжийн хамгаалалтыг нэмэгдүүлж, аюулгүй байдлын шаардлага, дэд бүтцийг сайжруулах;	Засгийн газар (ЭМЯ)
1.5/	бүртгэлийн заавраас зөрүүтэй, чанаргүй болон хадгалалтын хугацаа дууссан, горим алдагдсан эм, эмийн бүтээгдэхүүний устгалын бүртгэлийг цахимжуулах арга хэмжээг авах;	Засгийн газар (ЭМЯ)
1.6/	Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газрын харьяа Эм шинжлэх лабораторийг Хүнсний аюулгүй байдлын үндэсний лавлагаа лабораторитой нэгтгэж, нэгдсэн удирдлага, зохион байгуулалт-тайгаар ажиллах нөхцөлийг бүрдүүлэх, лабораторийн байр, шаардлагатай урвалж бодис, багаж, тоног төхөөрөмжийн санхүүжилтийг төсвийн болон олон улсын төсөл, хөтөлбөрийн хүрээнд 2024 оны 07 дугаар сарын 01-ний өдрийн дотор шийдвэрлэх;	Засгийн газар (ЭМЯ)
1.7/	эмийн цувралын чанарыг санамсаргүй түүврийн аргаар хянах тогтолцоог нэвтрүүлэх;	Засгийн газар (ЭМЯ)
1.9/	хүүхдэд эрүүл мэндийн боловсрол олгох чиглэлээр холбогдох төрийн захиргааны төв байгууллагын үйл ажиллагааг уялдуулж, хугацаатай үүрэг даалгавар өгөх;	Засгийн газар (БЯ, ЭМЯ)
1.10/	Монгол Улсын эмийн бүртгэлд бүртгэгдээгүй эм, эрүүл мэндийн нэмэлт бүтээгдэхүүнийг олон нийтийн цахим сүлжээгээр сурталчлахыг хориглох, сурталчилсан тохиолдолд хариуцлага хүлээлгэх талаар төрийн байгууллагуудын уялдааг хангах;	Засгийн газар (ЭМЯ)
1.11/	Эмийн үнийн өсөлтийн шалтгаан, нөхцөлийг хянан шалгах үүрэг бүхий Монгол Улсын Их Хурлын хянан шалгах түр хорооны санал, дүгнэлтийг хэрэгжүүлэх;	Засгийн газар (ЭМЯ)
1.12/	Монгол Улсын Их Хурлын 2023 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн 60 дугаар тогтоолоор байгуулагдсан Эмийн үнийн өсөлтийн шалтгаан, нөхцөлийг хянан шалгах үүрэг бүхий Улсын Их Хурлын хянан шалгах түр хороо (цаашид Хянан шалгах түр хороо гэх) Монгол Улсын Их Хурлын хянан шалгах түр хорооны хяналт шалгалтаар илэрсэн асуудлыг шуурхай шалгаж, зөрчил, дутагдлыг арилгах арга хэмжээг авч, хуулиар хүлээсэн үүргээ биелүүлээгүй албан тушаалтны хариуцлагын асуудлыг 2024 оны 2 дугаар улиралд багтаан холбогдох хууль тогтоомжийн хүрээнд шийдвэрлэх.	Засгийн газар (ЭМЯ)
2	Монгол Улсын Их Хурлын хянан шалгах түр хорооноос эмийн үнийн өсөлтийн шалтгаан, нөхцөлд хийсэн хяналт шалгалтын явцад төрийн байгууллага дахь эм хангамжийн байгууллагын хамаарал, эм хангамжийн байгууллагын тусгай зөвшөөрөл олгох үйл ажиллагаанд үүссэн байж болзошгүй хувийн	Авлигатай тэмцэх газар, Улсын Ерөнхий прокурор

			ашиг сонирхлын зөрчлийн асуудлыг холбогдох хуулийн дагуу шалган, иргэд олон нийтэд нээлттэй мэдээлэхийг Авлигатай тэмцэх газар /З.Дашдаваа/-т, хяналт шалгалтаар илэрсэн гэмт хэргийн шинжтэй үйлдэл, эс үйлдэхүйг холбогдох хуулийн дагуу шалгаж, шийдвэрлүүлэхийг Монгол Улсын ерөнхий прокурор Б.Жаргалсайханд тус тус зөвлөсүгэй.	
9	Хууль баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай 2024.06.05 №71 /Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/	1.1/	1.Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийг баталсантай холбогдуулан дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газар /Л.Оюун-Эрдэнэ/-т даалгасугай: 1/Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолоор баталсан “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогод заасан “Монголын уламжлалт анагаах ухааныг орчин үеийн анагаах ухаантай хослуулан хөгжүүлж экспортод гарах гарцыг дэмжин брэнд болгох” заалтыг үе шаттайгаар хэрэгжүүлэх;	Засгийн газар (ЭМЯ)
		1.2/	уламжлалт эмийн үйлдвэрлэлийг хөгжүүлэхэд шаардлагатай хүний нөөцийг бэлтгэх, давтан сургах;	Засгийн газар (ЭМЯ)
		1.3/	уламжлалт эм, биобэлдмэлийн үйлдвэрлэлийг хөгжүүлж, экспортыг дэмжих зорилгоор шинжлэх ухаан, технологийн төсөл, судалгааны ажилд дэмжлэг үзүүлэх;	Засгийн газар (ЭМЯ)
		1.4/	уламжлалт эм, биобэлдмэл, эмнэлгийн хэрэгслийн үйлдвэрлэлд ашиглах түүхий эд, сав, баглаа боодол, тоног төхөөрөмжид татварын хөнгөлөлт, чөлөөлөлт үзүүлэх, хөнгөлөлттэй зээл олгох асуудлыг бодлогоор дэмжих;	Засгийн газар (ЭМЯ)
		1.5/	үндэсний түвшинд био-эквивалент чанарын судалгаа хийх чадавх бүрдүүлэх зорилгоор Эрүүл мэндийн тухай хуулийн 15.1.7, 15.1.11, 15.1.13-т заасан байгууллагыг лабораторийн тоног төхөөрөмж, урвалж бодисоор хангах, хүний нөөцийг сургаж бэлтгэхэд шаардагдах санхүүжилтийг улсын төсөвт жил бүр тусгаж, 2026 оны 01 дүгээр сарын 01-ний өдрийн дотор бүрэн шийдвэрлэсэн байх;	Засгийн газар (ЭМЯ)
10	Монгол Улсын Их Хурлын 2024 оны 38 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангах талаар авах арга хэмжээний тухай 2024.08.30 №30	1.1/	1.“Монгол Улсын Их Хурлын хянан шалгах түр хорооноос эмийн үнийн өсөлтийн шалтгаан, нөхцөлд хяналт шалгалт хийсэнтэй холбогдуулан авах арга хэмжээний тухай” Монгол Улсын Их Хурлын 2024 оны 38 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангах дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газар /Л.Оюун-Эрдэнэ/-т даалгасугай: 1/Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийг хэрэгжүүлэх бэлтгэл ажлыг хангаж итгэлцлийн зохистой дадлыг хэрэгжүүлэх хүрээнд эмийн зохицуулалтын үнэлгээгээр Дэлхийн эрүүл мэндийн байгууллагаас хүлээн зөвшөөрсөн эмийн зохицуулалтын эрх бүхий байгууллагатай хамтран ажиллах;	Засгийн газар (ЭМЯ)
		1.2/	гаалийн болон татварын байгууллагатай	Засгийн

		мэдээлэл солилцох тогтолцоог бүрдүүлсний үндсэн дээр эм, эмнэлгийн хэрэгслийн цахим мэдээллийн санг хөтөлж, эмийн бодит үнийн мэдээллийг иргэдэд ил тод, нээлттэй болгох, чанарын шаардлага хангасан эм, эмнэлгийн хэрэгслээр иргэдийг хангах, хүртээмжийг нэмэгдүүлэх;	газар (ЭМЯ)
	1.3/	эмийн аюулгүй байдлын хяналт, зохицуулалтын тогтолцоо, үйл ажиллагааг боловсронгуй болгох талаар судлан санал танилцуулах.	Засгийн газар (ЭМЯ)

Гурав. Улсын Их Хурлын Байнгын хорооны тогтоолоор үүрэг, чиглэл болгосон заалт

№	Тогтоолын нэр, огноо, дугаар	Заалтын дугаар	Заалт	Хариуцах байгууллага
1.	Засгийн газарт чиглэл өгөх тухай 2018.05.22 №14	1.а.5/	хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагааг хуулийн тусгайлан зохицуулалтаар зохицуулж, дэмжлэгийн төрөл, хэлбэр, үйлчилгээг сайжруулах ажлыг зохион байгуулах.	Засгийн газар (ГБХНХЯ)
		1.а.3/	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас хувиараа хөдөлмөр эрхлэгч, нөхөрлөл, хоршоо, бичил аж ахуйн нэгжид олгодог жижиг зээлийн үйл ажиллагааг Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангаас жижиг, дунд үйлдвэрүүдэд олгодог зээлийн үйл ажиллагаатай харилцан шаталсан байдлаар уялдаатай байх хууль эрх зүйн орчныг бий болгох;	Засгийн газар (ГБХНХЯ)
2.	Засгийн газарт чиглэл өгөх тухай 2018.06.22 №17	1.6/	мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын чанарын баталгаажилтыг сайжруулах, суралцагч, төгсөгчдийг их, дээд сургуульд шатлан суралцах нөхцөлийг хангах зорилгоор боловсролын байгууллагууд хоорондын кредит үнэлгээг харилцан хүлээн зөвшөөрөх журам батлах;	Засгийн газар (БЯ)
		2	Байнгын хорооны тогтоолын хэрэгжилтийг хангах үүднээс хийх ажлын төлөвлөгөө гаргаж, жил бүрийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл болон улсын төсөвт тусгахыг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд /С.Чинзориг/-д даалгасугай.	Засгийн газар (ГБХНХЯ)
3.	Хүүхдийн эрхийн тухай, Хүүхэд хамгааллын тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай 2018.12.20 №24	1.4/	хүүхдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг хэрэгжүүлэх хүрээнд хүүхдийн сургууль, цэцэрлэг, дотуур байр, нийтийн эзэмшлийн зам, талбай, орон сууц болон гэр хороолол дахь гадаад, дотоод орчны аюулгүй байдлын эрсдэлийн үнэлгээ хийх, орчны нэгдсэн стандартыг баталж мөрдүүлэх;	Засгийн газар (ЭМЯ)
		1.11/	архи, тамхи, согтууруулах ундаагаар үйлчилдэг болон худалдан борлуулдаг цэгүүдийг сургуулийн ойр орчинд ажиллуулахгүй байх хуулийн хэрэгжилтийг хангуулж, сургууль, цэцэрлэгийн хүүхдийн хоол, хүнсний хангамжийн эрүүл ахуй, аюулгүй байдлыг хангах талаар холбогдох байгууллагын хяналтыг сайжруулах;	Засгийн газар (ЭМЯ)
		1.12/	агаарын болон орчны бохирдлоос хүүхдийн эрүүл мэндийг хамгаалах, урьдчилан сэргийлэх, эрүүл мэндэд нөлөөлөх сөрөг	Засгийн газар (ЭМЯ)

			нөлөөллийг бууруулах талаар боломжит бүх арга хэмжээг эрүүл мэндийн байгууллагаас авч хэрэгжүүлэх;	
4.	Засгийн газарт чиглэл өгөх тухай 2021.10.19 №05	1.2/	Эрүүл мэндийн даатгалын санд төр хариуцан төлөх эрүүл мэндийн даатгалын шимтгэлийг үе шаттайгаар нэмэгдүүлэх, эрүүл мэндийн даатгалын сангийн зарцуулалтыг оновчтой болгох, төлөвлөлтийг сайжруулах, санг болзошгүй эрсдэлээс хамгаалах;	Засгийн газар (ЭМЯ)
		1.4/	Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын эрх үүрэг, бүтцийг оновчтой, боловсронгуй тогтоох талаар санал боловсруулж 2022 оны 01 дүгээр сард багтаан Байнгын хороонд танилцуулах, холбогдох хуулийн төслийг Улсын Их Хурлын 2022 оны хаврын ээлжит чуулганы хугацаанд өргөн мэдүүлэх;	Засгийн газар (ЭМЯ)
		1.5/	Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийг хараат бус, мэргэжлийн, бие даасан байдлаар ажиллуулах, зөвлөлийн гишүүдийг нээлттэй сонгон шалгаруулах, хяналтын чиг үүрэг, хариуцлага, урамшууллыг оновчтой тогтоох, холбогдох хууль тогтоомжийн төслийг Улсын Их Хурлын 2021 оны намрын ээлжит чуулганы хугацаанд өргөн мэдүүлэх;	Засгийн газар (ЭМЯ)
		1.6/	Эрүүл мэндийн даатгалын сангаас зардлын төлбөрийг нь хариуцах өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвөөс үзүүлэх эрүүл мэндийн анхан шатны тусламж, үйлчилгээний нэг иргэнээр тооцсон төлбөрийн хэмжээг 2022 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс 2 дахин нэмэгдүүлэх, сум, тосгоны эрүүл мэндийн төвөөс үзүүлэх эмнэлгийн тусламж, үйлчилгээг гүйцэтгэлийн санхүүжилтийн хэлбэрт бүрэн шилжүүлэх; /НББХ-ны 2021.10.26-ны өдрийн 06-р тогтоолоор өөрчлөлт оруулсан/	Засгийн газар (ЭМЯ)
		1.7/	Хуулийн хүрээнд төрийн болон орон нутгийн өмчит төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, нэгдсэн эмнэлгийн засаглалыг хагас бие даасан тогтолцоонд шилжүүлэх, төлөөлөн удирдах зөвлөлийг байгуулах ажлыг 2021 оны 12 дугаар сард багтаан дуусгах, Багануур, Баянгол, Налайх, Чингэлтэй дүүргийн эрүүл мэндийн төвийн үйл ажиллагааг нэгдсэн эмнэлэг болгож, хагас бие даасан тогтолцоонд шилжүүлэх боломжийг бүрдүүлэх;	Засгийн газар (ЭМЯ)
		1.8/	Эмнэлгүүд бие даан төсвөө захиран зарцуулах боломжийг зохих журмын дагуу бүрдүүлэх замаар эмч, ажилчдын цалин хөлсийг гүйцэтгэлд нь суурилан нэмэгдүүлэх, анхан шатны эрүүл мэндийн байгууллагын эмч, мэргэжилтний цалингийн доод жишгийг нэмэгдүүлж чадварлаг эмч, сувилагч, асрагч нарын ажиллах хөшүүргийг бий болгох;	Засгийн газар (ЭМЯ)
		1.9/	Эмч, эрүүл мэндийн ажилтнуудыг эрсдэлийн албан журмын болон сайн дурын даатгалд хамруулах боломжийг судалж, шийдвэрлэх;	Засгийн газар (ЭМЯ)
		1.10/	Эрүүл мэндийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах замаар өрхийн эрүүл мэндийн төвийг хязгаарлагдмал	Засгийн газар (ЭМЯ)

			хариуцлагатай нөхөрлөл болгож өрхийн эрүүл мэндийн төвийн нийт ажилтны 60-аас доошгүй хувь нь тухайн нөхөрлөлийн гишүүн байхаар тусгах хуулийн төслийг 2021 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх; /НББХ-ны 2021.10.26-ны өдрийн 06-р тогтоолоор өөрчлөлт оруулсан/	
		1.11/	Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газарт мэргэжлийн хяналтын төв болон орон нутгийн байгууллагын эм, эмнэлгийн хэрэгслийн хяналтын чиг үүргийг батлагдсан орон тооны дагуу 2021 оны 12 дугаар сард багтаан шилжүүлэх;	Засгийн газар (ЭМЯ)
		1.12/	Нийслэл, аймаг, сумын бүх шатлалын эмнэлгүүдэд салбарын холбогдох хууль, тогтоомжууд болон санхүүжилтийн шинэчлэлийн талаар тайлбарлан таниулах сургалтыг тогтмол зохион байгуулах, гүйцэтгэлийн санхүүжилтийг цаг тухайд нь хасагдалгүй авах нөхцөл боломжоор тухай бүр хангаж ажиллах;	Засгийн газар (ЭМЯ)
		1.13/	Хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагаас даатгуулагчид үзүүлэх тусламж, үйлчилгээний чанарт тавих хяналтыг сайжруулах;	Засгийн газар (ЭМЯ)
		1.16/	Нийслэл, аймаг, сумын бүх шатлалын эрүүл мэндийн байгууллагуудын боловсон хүчин, барилга байгууламж, тоног төхөөрөмжийн хувьд тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэх, эрүүл мэндийн байгууллагын ажилтнуудын нийгмийн баталгааг хангах чиглэлээр дунд болон урт хугацааны бодлого боловсруулж Улсын Их Хуралд танилцуулах, шаардлагатай төсвийг Улсын төсвийн жил бүрийн төсөлд тусган үе шаттайгаар шийдвэрлэх.	Засгийн газар (ЭМЯ)
5.	Чиглэл өгөх тухай 2022.06.07 №14	1.4/	Ахмад настны хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төлөвлөгөөний хэрэгжилтийг эрчимжүүлэх, санхүүжилтийг үр ашигтай, ил тод зарцуулах, нийгмийн хөгжилд ахмад настны оролцоог нэмэгдүүлэх;	Засгийн газар (ГБХНХЯ)
		1.6/	Улсын хэмжээнд сум бүрийг "Ахмадын өргөө"-тэй болгох ажлыг үе шаттайгаар зохион байгуулж, Ахмадын өргөөний урсгал зардал, тоног төхөөрөмжийг шийдвэрлэх, ажиллаж буй ахмадын урамшууллыг тухайн орон нутгийн төсөвт тусгаж, санхүүжүүлэх;	Засгийн газар (ГБХНХЯ)
		1.9/	Монгол Улсын 2011 оны төсвийн тухай хуульд тусгагдсан Геронтологийн үндэсний төвийн барилга угсралтын ажлыг эрчимжүүлэх, шаардлагатай санхүүжилтийг 2023 оны Улсын төсөвт тусгаж, 2025 онд ашиглалтад оруулах;	Засгийн газар (ЭМЯ)
		1.10/	Ахмад настанд үзүүлж буй эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар, хүртээмжийг (оношлогоо, эмчилгээний нэр төрөл, өрөө тасалгааны тоо хүртээмж, мэргэшсэн эмч, мэргэжилтний тоо) нэмэгдүүлэх;	Засгийн газар (ЭМЯ)
6.	Чиглэл өгөх тухай 2022.06.15 №18	1.1/	Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах ажлын хүрээнд дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газар (Л.Оюун-	Засгийн газар (ЭМЯ)

			Эрдэнэ)-т чиглэл болгосугай: 1/ Эмч, эмнэлгийн мэргэжилтний мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх, анагаах ухааны дэвшилтэт техник, тоног төхөөрөмжөөр эмнэлгүүдийг хангах замаар Монгол Улсад оношлох, эмчлэх боломжгүй байгаа өвчнийг дотооддоо оношилж, эмчлэх боломжийг бүрдүүлэх;	
		1.2/	Монгол Улсад оношлох, эмчлэх боломжгүй өвчин, эмгэгийн улмаас гадаад улсад зайлшгүй шаардлагаар эмчилгээ хийлгэх иргэнд үзүүлэх санхүүгийн дэмжлэгийг 2023 оноос үе шаттай нэмэгдүүлэх, эмчилгээний зардлыг төрөөс хариуцах боломжийг судалж 2022 онд багтаан Байнгын хороонд танилцуулах;	Засгийн газар (ЭМЯ)
		1.3/	эрүүл мэндийн сайн дурын нэмэлт даатгалыг хөгжүүлэх, эрүүл мэндийн салбарын гадаад хамтын ажиллагааг өргөжүүлэх замаар зайлшгүй шаардлагаар гадаад улсад эмчлүүлэх өвчтөнөөс гарах эмчилгээний зардлыг хөнгөвчлөх асуудлыг судлах;	Засгийн газар (ЭМЯ)
		1.5/	Иргэдэд эрүүл, зөв амьдралын хэв маягийг төлөвшүүлэх, соён гэгээрүүлэх ажлыг тогтмол зохион байгуулах;	Засгийн газар (ЭМЯ)
		2	Энэ тогтоолд заасан холбогдох арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардлагатай төсөв, хөрөнгийг 2023 оноос эхлэн улсын төсөвт тусгаж, санхүүжүүлэхийг Сангийн сайд (Б.Жавхлан)-д даалгасугай.	Засгийн газар (СЯ)
7.	Чиглэл өгөх тухай 2023.03.28 №05	1.1/	1.Хүүхдийн эрхийн тухай, Хүүхэд хамгааллын тухай хуулийн хэрэгжилтийг хангах хүрээнд дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газар /Л.Оюун-Эрдэнэ)-т чиглэл болгосугай: НЭГ.Хүүхэд хамгааллын тухай хуулийн хүрээнд: 1/Монгол Улсын хууль тогтоомжийг 2024 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэлд тусгагдсан Хүүхэд хамгааллын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл, Гэр бүлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл, Нийгмийн ажлын тухай хуулийн төслийг боловсруулж Улсын Их Хурлын 2023 оны намрын ээлжит чуулганы хугацаанд өргөн мэдүүлэх,	Засгийн газар (ГБХНХЯ)
		1.5/	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Боловсрол, шинжлэх ухааны сайд, Эрүүл мэндийн сайдын 2021 оны 12 дугаар сарын 30-ны өдөр хамтран баталсан Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд, хөгжлийн цогц дэмжлэг үзүүлэх аргачлал, маягт, шинэчлэн батлах тухай тушаалын хэрэгжилтийг хангуулах хүрээнд "Тусгай хэрэгцээт хүүхдийн эрт дэмжлэгийн нөхцөл байдлын үнэлгээ", хүүхэд бүрийг хүчирхийлэлд өртөхөөс өмнө хийх багш, сургууль, цэцэрлэгийн нийгмийн ажилтанд суурилсан "Хүчирхийлэлд өртөж болзошгүй байдлын үнэлгээ"-г боловсруулах ажлын хэсгийг тус 3 яамны төлөөллийг оролцуулан байгуулах, үнэлгээг 2023 оны 03 дугаар улиралд багтаан боловсруулах;	Засгийн газар (ГБХНХЯ, БЯ, ЭМЯ)

1.6/	Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төв дээр сэтгэцийн хурц эмгэг өөрчлөлттэй хүүхэд, эцэг эх асран хамгаалагч нь тогтоогдохгүй байгаа, хагас, бүтэн өнчин хүүхдэд үйлчилгээ үзүүлэх бүтэц, орон тоог нэмэгдүүлэх;	Засгийн газар (ЭМЯ)
1.7/	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын харьяа Сургалт-хүмүүжлийн тусгай байгууллагын дэд бүтцэд холбогдсон, ерөнхий боловсролын сургуулийн барилгын төлөвлөлтийн дүрэмд нийцсэн шинэ барилгад үйл ажиллагаагаа хэвийн явуулахад шаардагдах төсөв, хөрөнгийг 2024 оноос эхлэн улсын төсөвт тусгаж, барилгыг 2025 онд ашиглалтад оруулах, шинээр ашиглалтад орох барилгад нүүж орох хүртэлх хугацаанд тус сургалт-хүмүүжлийн тусгай байгууллагад шаардлагатай урсгал засварын зардлыг шийдвэрлэх;	Засгийн газар (СЯ, ХЗДХЯ)
1.8/	хүүхэд хамгааллын хариу үйлчилгээ үзүүлэх түр хамгаалах байр нь хохирогчийг хамгаалах байрны үйлчилгээнд тавих нийтлэг шаардлагад тусгагдсан хүний үндсэн болон тусгай хэрэгцээг бүрэн хангах, хүүхдэд ээлтэй орчин нөхцөлийг бүрдүүлэх, шаардагдах хөрөнгө, санхүүжилтийг нэмж тусгах;	Засгийн газар (ГБХНХЯ, СЯ)
1.10/	"Хамтарсан багийн ажиллах, үйл ажиллагааг санхүүжүүлэх журам"-ыг нийгмийн хамгааллын, хууль зүйн, эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд яаралтай шинэчлэн батлах;	ГБХНХС, ХЗДХС, ЭМС
1.11/	Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн хөгжил, хамгаалал, эрхийн талаарх хууль тогтоомжийн хэрэгжилтэд дүн шинжилгээ хийх, хэрэгжилтийг сайжруулах хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлэх;	Засгийн газар (ГБХНХЯ)
2.1/	ХОЁР.Хүүхдийн эрхийн тухай хуулийн хүрээнд: 1/хүүхэд хөгжлийн чиг үүргийн байгууллагуудын үйл ажиллагааг дэмжих, Хүүхдийн номын сан, Хүүхэлдэйн театр, Хүүхдийн урлан бүтээх төвийн барилга байгууламжийг шинэчлэх зардлыг улсын төсөвт шат дараатай тусгаж, шийдвэрлэх, хүртээмжийг нэмэгдүүлэх, үйлчилгээг бүсчилсэн хэлбэрээр ажиллуулах, хүүхдийн хөгжил төлөвшилд хүрч үйлчлэх нөхцөл бүрдүүлэх;	Засгийн газар (ГБХНХЯ)
2.2/	цахим орчинд хүүхдийн эрхийг хамгаалах, хүүхдийн нэр төр, алдар хүндэд халдах, гутаан доромжлох, залилах, хүчирхийлэлд уриалах, садар самуун явдлыг сурталчлах зэрэг гэмт хэрэг, зөрчлийн үйлдлүүдийг таслан зогсоох, хууль бус үйл ажиллагаатай тэмцэх, урьдчилан сэргийлэх арга хэмжээг нэн яаралтай авах;	Засгийн газар (ХЗДХЯ, ГБХНХЯ)
2.3/	Боловсрол, шинжлэх ухааны яамнаас Монголын үндэсний олон нийтийн радио телевиз, Харилцаа холбооны зохицуулах хороо зэрэг холбогдох байгууллагуудтай 2019 оны 03 дугаар сарын 15-ны өдөр байгуулсан хүүхдийг сэрүүн байх цагаар хүмүүжил төлөвшилд сөрөг нөлөө үзүүлэх тодорхой	Засгийн газар (БЯ)

			төрлийн контентыг хязгаарлахтай холбоотой харилцан ойлголцлын санамж бичгийн хэрэгжилтийг хангах, үр дүнг тайлагнах;	
		2.5/	Хүүхдийн эрхийн хэрэгжилтийн цогц үнэлгээ хийж, хэрэгжихгүй байгаа шалтгаан нөхцөлийг тодорхойлох, хэрэгжилтийг хангах зөвлөмж боловсруулж 2023 оны хаврын ээлжит чуулганы хугацаанд Байнгын хороонд танилцуулах;	Засгийн газар (ГБХНХЯ)
		2.6/	Хүүхдийн эрхийн байцаагчийн ажил үүргийн хуваарийг боловсронгуй болгох, нийгэмд таниулах ажлыг эхлүүлэх.	Засгийн газар (ГБХНХЯ)
		2	Энэ тогтоолын биелэлтийг Нийгмийн бодлогын байнгын хороонд 2023 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор танилцуулахыг Монгол Улсын Засгийн газар /Л.Оюун-Эрдэнэ/-т үүрэг болгосугай.	Засгийн газар (ГБХНХЯ)
8.	Засгийн газарт чиглэл өгөх тухай 2024.04.02 №04	1.1/	Монгол Улс дахь В, D гепатит вирусын халдварын тархалтыг бууруулах, урьдчилан сэргийлэх, эмчлэх зорилгоор дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газар (Л.Оюун-Эрдэнэ)-т чиглэл болгосугай: 1/1"Элэг бүтэн Монгол" арга хэмжээний төлөвлөгөө (2022-2025)-ний хэрэгжилтийг эрчимжүүлэх;	Засгийн газар (ЭМЯ)
		1.2/	D вируст гепатитын халдвартай иргэдийн эмчилгээний зардлыг 2025 оноос эхлэн жил бүрийн Улсын төсөвт тусгах арга хэмжээ авах;	Засгийн газар (ЭМЯ)
		1.3/	В вируст гепатитын эсрэг дархлал тогтцыг судлан, нэмэлт дархлаажуулалтад хамруулах асуудлыг судалж, шийдвэрлэх;	Засгийн газар (ЭМЯ)
		1.4/	В, D, С вируст гепатитын халдвараас урьдчилан сэргийлэх, халдвар хамгааллын хяналтыг сайжруулах, мэдээлэл сургалт, сурталчилгааны ажлыг өргөжүүлэх;	Засгийн газар (ЭМЯ)
		1.5/	В, D вирусын халдвартай иргэдийг элэгний хорт хавдрын эрт илрүүлэгт хамруулах талаар судлах, боломжит арга хэмжээг авч, шийдвэрлэх.	Засгийн газар (ЭМЯ)
9.	Хуулийн хэрэгжилтийг хангах арга хэмжээний тухай 2025.05.13 №06	1.1	1.Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенц, Нэгдсэн Үндэстний Байгууллагын Монгол Улсын хоёр болон гуравдугаар нэгтгэсэн тайланд хийсэн ажиглалт, дүгнэлт, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн хэрэгжилтийг хангах хүрээнд дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газар /Л.Оюун-Эрдэнэ/-т даалгасугай: 1/Монгол Улсын Үндсэн хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1 дэх хэсэг, 16 дугаар зүйлийн 16.5, 16.6, 16.7, 16.13, 16.14 дэх заалтад заасан хүний үндсэн эрх, эрх чөлөөг хангах зорилгоор хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжид заасан дүрэм, журам, стандартын хэрэгжилтийг сайжруулах, батлагдаагүй журмуудыг боловсруулан батлах, мөн шаардлагатай журмуудыг шинэчлэн баталж, хэрэгжүүлэх	Засгийн газар (ГБХНХЯ)
		1.2	Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн	Засгийн

	тухай Нэгдсэн Үндэстний Байгууллагын конвенцын шинэ нэр томъёотой, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийг нийцүүлүүлж, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийг зөрчсөн иргэн, хуулийн этгээдэд хүээлгэх хариуцлагыг зөрчлийн тухай хуульд тусгах, Гамшгаас хамгаалах тухай хууль болон Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн нийцлийг хангаж, холбогдох хуулийн төслийг Монгол Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх;	газар (ХЗДХЯ, ГБХНХЯ)
1.3	Оюуны хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг иргэний эрх зүйн чадамжгүй гэж шүүхийн журмаар тогтоох, шүүхэд хүсэлт гаргах,шүүн таслах ажиллагаанд оюуны хөгжлийн бэрхшээлтэй иргэний өөрийнх нь оролцоо, түүний хүсэл зоригийг харгалзан үзэх, хөгжлийн бэрхшээлтэй хүн бие даан хэлцэл хийх эрх зүйн орчныг бүрдүүлэх, хөгжлийн бэрхшээлтэй иргэд өөрсдийн боломжит хэлбэрээр гаргасан өргөдөл, хүсэлт, гомдлыг шийдвэрлэх талаарх зохицуулалтыг холбогдох хуульд өөрчлөлт оруулах, уг хуулийн төслийг боловсруулж, УИХ-д өргөн мэдүүлэх;	Засгийн газар (ХЗДХЯ, ГБХНХЯ)
1.4	Барилга, байгууламж, авто зам зэрэг нийтийн дэд бүтцийн байгууламжийг ашиглалтад оруулах улсын комисст орж ажиллаж байгаа төрийн бус болон иргэний нийгмийн байгууллагын төлөөллүүд үйл ажиллагаагаа нээлттэй, ил тод байлгах, тулгамдаж байгаа асуудлыг тухайн комиссыг томилсон эрх бүхий байгууллагад гаргаж, шийдвэрлүүлэх эрх зүйн орчныг бүрдүүлэх;	Засгийн газар (ХЗДХЯ)
1.5	Засгийн газрын 2024 оны 102 дугаар тогтоолоор баталсан"гадаадын болон дотоодын дээд боловсролын сургалтын байгуулллагад суралцагчид тэтгэлэг, зээл олгох, эргэн төлүүлэх, буцалтгүй тусламж олгох, дэмжлэг үзүүлэх журам"-ын зорилтот бүлгийн хүрээнд гэр бүлийн гишүүдийг тодорхойлсон зохицуулалт нь Гэр бүлийн тухай хуулийн нэр томъёоны агуулгад нийцэхгүй байгаа тул уг зөрчлийг арилгаж, холбогдох журмыг хууль тогтоомжид нийцүүлэх арга хэмжээг авч хэрэгжүүлэх;	Засгийн газар (ЭМЯ)
1.6	Засгийн газрын 2023 оны 402 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан "Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах зөвлөлийн ажиллах журам"-ын хэрэгжилтийн хангах;	Засгийн газар (ГБХНХЯ)
1.7	Хүүхдийн хөгжлийн бэрхшээл, өвчин, эмгэгийг оношилгоо, эмчилгээний дэвшилтэт технологийг ашиглан эрт илрүүлэх тоног, төхөөрөмжийн зардлыг Хүүхдийн төлөө сангийн хөрөнгөөс зарцуулах боломжийг судалн шийдвэрлэх;	Засгийн газар (ГБХНХЯ, ЭМЯ)
1.8	Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг тухайн бэрхшээлээс нь үл хамаарч бүх шатны боловсролын байгууллагад бүрэн хамруулах, шаардлагатай хүний нөөцийг бэлтгэх, сурч боловсрох эрхийг хангах;	Засгийн газар (ГБХНХЯ, БЯ)

1.9	анхан шатны эмнэлгийн тусламж, үйлчилгээ болон төрийн бусад үйлчилгээг үзүүлж байгаа байгууллагуудад хөгжлийн бэрхшээлийн талаарх ойлголт, хандлагын сургалтыг зохион байгуулж, хөгжлийн бэрхшээлтэй хүнд ээлтэй, хүртээмжтэй үйлчлэх орчныг бүрдүүлэх;	Засгийн газар (ЭМЯ, ГБХНХЯ)
1.10	нийслэл, дүүрэг, орон нутагт амьдардаг хөгжлийн бэрхшээлтэй болон олдмол хөгжлийн бэрхшээлтэй хүнд уян хатан байдлаар үйлчилгээ үзүүлэх, туслах бүтээгдэхүүн, тохирох хэрэглэгдэхүүн /боломжит тохируулга/-аар хангах, ганцаарчилсан тусламж, дэмжлэг, зөвөлгөө өгөхөд чиглэсэн арга хэмжээг хэрэгжүүлэх талаар төрийн байгууллагууд үйл ажиллагааныхаа төлөвлөгөөнд тусгах;	Засгийн газар
1.11	Хөдөлмөрийн тухай хуулийн 144 дүгээр зүйлд заасан хөгжлийн бэрхшээлтэй хүнийг ажиллуулах, ажиллуулаагүй бол ажиллуулбал зохих орон тоо тутамд ногдох төлбөрийг дэмжих санд төлүүлэх арга хэмжээг хэрэгжүүлэх, Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр, арга хэмжээг хөгжлийн бэрхшээлтэй хүний эрх ашгийг хамгаалах төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэхдээ нэг жилээр хязгаарлахгүйгээр, үр дүнд суурилан хугацааг сунгах асуудлыг судлан шийдвэрлэх;	Засгийн газар (ГБХНХЯ)
1.12	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 8 дугаар зүйлийн 84.5 дахь хэсэгт "ажиллах хүчний 30 ба түүнээс дээш хувийг хөгжлийн бэрхшээлтэй хүн эзэлдэг, 25 ба түүнээс дээш ажилтантай аж ахуй эрхлэгч үйлдвэрлэсэн" гэсэн хуулийн зохицуулалтыг бараа, ажил үйлчилгээ худалдан авах тендерт тус хуулийн хэрэгжилтийг хангуулах;	Засгийн газар (ГБХНХЯ)
1.13	Хөгжлийн бэрхшээлтэй хүнд шаардлагатай сэргээн засах үйлчилгээний төрлийг нэмэгдүүлэх, холбогдох журмыг хуульд нийцүүлэх, энэ чиглэлээр ажиллах мэргэжлийн боловсон хүчнийг нэмэгдүүлэх бодлого боловсруулан хэрэгжүүлэх, нийгмийн халамжийн сангаас олгодог ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэн, хүүхдэд олгох, протез, ортопед, тусгай хэрэгслийн жишиг үнэ, тэдгээрийн хөнгөлөлтийг зах зээлийн ханштай уялдуулан жил бүр шинэчлэн тогтоох, туслах бүтээгдэхүүний жагсаалтыг Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын зайлшгүй шаардлагатай туслах бүтээгдэхүүний жагсаалттай харьцуулан шинэчлэх, зарим туслах бүтээгдэхүүнийг жил бүр олгох асуудлыг судлан шийдвэрлэх;	Засгийн газар (ГБХНХЯ)
1.14	хөгжлийн бэрхшээлтэй хүний тоон мэдээлэл, ерөнхий статистик, судалгааны мэдээллийг холбогдох төрийн байгууллага нээлттэй байршуулах, нийгмийн халамжийн болон эрүүл мэндийн үйлчилгээ тогтмол авч байгаа, авах шаардлагатай хүмүүсийн мэдээллийн цахим санг олон улсын түвшинд харьцуулж болохуйц хэлбэрээр бүрдүүлэх, хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хамгаалах	Засгийн газар (ГБХНХЯ)

			чиглэлээр төсөвлөсөн төсөв, санхүүгийн төлөвлөгөө, тайлан, мэдээллийг хөгжлийн бэрхшээлтэй хүн, энэ чиглэлээр ажилладаг төрийн бус байгууллага, иргэний нийгмийн байгууллага болон олон нийтэд нээлттэй мэдээлэх;	
		1.15	Хөгжлийн бэрхшээлтэй хүний мэдээлэл хүлээн авах эрхийг хангах зорилгоор дижитал хүртээмжийг нэмэгдүүлэх хүрээнд төрийн байгууллагуудын цахим хуудсыг вэб контентын хүртээмжийн удирдамж WCAG/-ийг баримталж боловсруулах, цахим орчинд хүртээмжтэй платформ, мэдээллийн стандарт, технологийн шийдлийг хэрэгжүүлэх, төрийн үйлчилгээнд хамрагдсан хөгжлийн бэрхшээлтэй хүний эмзэг мэдээллийг чанд нууцлах;	Засгийн газар (ГБХНХЯ)
		1.16	Хүнийг хөгжлийн бэрхшээлтэй болохоос урьдчилан сэргийлэх, хүүхдийн хөгжлийн хоцрогдол, нурууны муруйлт, хавтгай тавхай зэрэг хөгжлийн бэрхшээлтэй болгох согогийг бага насанд нь илрүүлэх, холбогдох арга хэмжээ авах механизмыг бүрдүүлэх, тэдэнд хөгжлийн дэмжлэг үзүүлэх чиглэлээр үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулан ажиллах, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль, холбогдох дүрэм, журам, стандартын хэрэгжилтийг хангаж, хүний эрүүл мэндийг хамгаалах;	Засгийн газар (ГБХНХЯ)
		1.17	Хөгжлийн бэрхшээлтэй хүнийг нийгмийн харилцаанд эрх тэгш оролцох боломжийг баталгаажуулах зорилгоор нийгмийг соён гэгээрүүлэх аяныг зохион байгуулах;	Засгийн газар (ГБХНХЯ)
		2	Энэ тогтоолын биелэлтийг Монгол Улсын Их Хурлын Нийгмийн бодлогын байнгын хороонд УИХ-ын 2026 оны хаврын ээлжит чуулганы хугацаанд багтаан танилцуулахыг Монгол Улсын Засгийн газар /Л.Оюун-Эрдэнэ/-т үүрэг болгосугай.	Засгийн газар (ГБХНХЯ)
10.	Засгийн газарт чиглэл өгөх тухай 2025.07.01 №09	1.1	Нийгмийн даатгалын шимтгэлийг бууруулах тухай нийтийн өргөдлийг судалж, шийдвэрлэх хүрээнд дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газар (Г.Занданшатар)-т даалгасугай; 1.1.Нийгмийн даатгалын сангийн орлого, зарлагын тэнцвэртэй байдлыг алдагдуулалгүйгээр зарим даатгуулагчийн нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийг уян хатан тогтоох боломжийг судалж, холбогдох хуулийн төсөлд тусган боловсруулж Монгол Улсын Их Хуралд 2025 оны намрын ээлжит чуулганы хугацаанд өргөн мэдүүлэх;	Засгийн газар (ГБХНХЯ)
		1.2	Нийгмийн даатгалын сангийн хөрөнгийн зохистой удирдлагыг төлөвшүүлж, нийгмийн даатгалын сангаас "Капитал банк" дахь банкны эрх хүлээн авагч, "Чингис хаан" банк ХХК-иас нэхэмжилсэн авлагыг барагдуулах арга хэмжээг яаралтай авч санг алдагдалгүй түвшинд хүргэх;	Засгийн газар (ГБХНХЯ)
		1.3	Даатгуулагчид ирэх санхүүгийн ачааллыг бууруулах хүрээнд тэтгэврийн зардлыг Үндэсний баялгийн сангаас санхүүжүүлэх	Засгийн газар (ГБХНХЯ)

11.	Засгийн газарт чиглэл өгөх тухай 2025.07.08 №10		боломжийг судалж, танилцуулах;	
		2	Энэ тогтоолын биелэлтийг Монгол Улсын Их Хурлын Нийгмийн бодлогын байнгын хороонд УИХ-ын 2025 оны намрын ээлжит чуулганы хугацаанд багтаан танилцуулахыг Монгол Улсын Засгийн газар /Г.Занданшатар/-т үүрэг болгосугай.	Засгийн газар (ГБХНХЯ)
		1	Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээ, залуучуудын өнөөгийн нөхцөл байдлын үр дүнд үндэслэн Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг залуучуудын боловсрол, эрүүл мэнд, хөдөлмөр эрхлэлт, хөгжил, оролцоо, нийгмийн асуудлыг иж бүрнээр шийдвэрлэх зорилго, зорилтыг тусгасан Хөгжлийн зорилтот хөтөлбөрийн төслийг тус тус боловсруулж, 2025 оны намрын ээлжит чуулганы хугацаанд багтаан Монгол Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхийг Монгол Улсын Засгийн газар (Г.Занданшатар)-т даалгасугай.	Засгийн газар (ЭЗХЯ)
		2	Монгол Улсын Их Хурлаас баталсан "Алсын хараа 2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуульд заасан Хөгжлийн зорилтот хөтөлбөрийн хүрээнд боловсрол, залуу малчид, орон нутгийн залуус, хөдөлмөр эрхлэлт, хүмүүжил, ёс суртахуун гэсэн дараах 5 үйл ажиллагааг шаардлагатай санхүүжилтийн хамт улсын хөгжлийн жилийн төлөвлөгөө, улсын төсөвт тусган хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газар (Г.Занданшатар)-т даалгасугай:	Засгийн газар (ЭЗХЯ, СЯ)
		2.1/	Эх орондоо дэлхийн жишигт нийцсэн боловсрол эзэмших нөхцөл бололцоог бүрдүүлэх хүрээнд дэлхийн шилдэг их сургуулиудын зэрэглэлээр тухайн жилд тогтоосон эрэмбийн жагсаалтын эхний 50-д багтсан сургуулиас багш, судлаач багш нарыг урьж ажиллуулах, тус сургуулийн салбарыг Монгол Улсад нээх боломжийг судлах, залуучуудын дижитал ур чадварыг сайжруулах чиглэлээр тэгш хүртээмжтэй боловсрол олгох;	Засгийн газар (БЯ)
		2.2/	гадаадад сурч боловсрол эзэмшсэн залуучуудыг эх орондоо ирж ажиллаж, амьдрахад болон залуучууд хөдөө, орон нутагт амьдрахад нөлөөлөх хүчин зүйлсийн судалгааг хийх, судалгааны үр дүнд тулгуурлан төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх;	Засгийн газар (БЯ)
		2.3/	залуу малчдыг дэмжих хүрээнд уламжлалт нүүдлийн мал аж ахуйн салбарыг уур амьсгалын өөрчлөлтийн сөрөг нөлөөллөөс хамгаалах, учирч болзошгүй эрсдэлийг бууруулах, дасан зохицох чиглэлээр тэдний хөгжил, оролцоог нэмэгдүүлэх, залуу малчдын гэр бүл төлөвлөлтийг дэмжих, амьдралын чанарыг сайжруулах, эдийн засгийн үр ашигтай бизнес эрхлэхийг дэмжих;	Засгийн газар (ССАЖЗЯ)
		2.4/	орон нутгийн залуучуудыг тухайн аймаг, сумандаа тогтвор суурьшилтай ажиллаж, амьдрах нөхцөл боломжоор хангах хүрээнд	Засгийн газар (ЭЗХЯ, СЯ,

			орон сууцны хөнгөлөлттэй зээлд, сум бүрт жилд 10-аас дээш өрхийг түрээсийн болон хувийн орон сууцанд хамруулах боломжийг судалж, холбогдох тооцооллыг танилцуулах;	ССАЖЗЯ)
		2.5/	зах хязгаар нутагт амьдарч буй залуучуудад чиглэсэн төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэх;	Засгийн газар (ССАЖЗЯ)
		2.6/	залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих чиглэлээр оюутны цагаар хөдөлмөр эрхлэх журмыг шинэчлэх, оюутны цагийн хөдөлмөрийн цалин хөлснөөс төлөх нийгмийн даатгалын шимтгэлийн хувь хэмжээг уян хатан тогтоох;	Засгийн газар (ГБХНХЯ, ССАЖЗЯ)
		2.7/	залуучуудын гарааны бизнесийг дэмжих хөтөлбөрийг хэрэгжүүлэх, ЖДҮ-ийг хөгжүүлэх сангийн зарцуулалтын тодорхой хувийг жижиг, дунд үйлдвэрлэл эрхэлж буй залуучуудад зарцуулах, залуучуудын хөгжлийг дэмжих санг байгуулах талаар судалж танилцуулах;	Засгийн газар (ГБХНХЯ, ССАЖЗЯ)
		2.8/	өсвөр үе залуучуудад хүмүүжил, ёс суртахууныг төлөвшүүлэх хүрээнд тэдний сэтгэцийн эрүүл мэндийг дэмжих, бие хүн болж төлөвшихөд чиглэсэн үйл ажиллагааг засаг захиргааны нэгжийн Засаг дарга бүр тэгш хамралтын зарчим дээр үндэслэн хэрэгжүүлэх.	Засгийн газар (ССАЖЗЯ)
		3	Энэ тогтоолын биелэлтийн явцыг Монгол Улсын Их Хурлын 2025 оны намрын ээлжит чуулганы хугацаанд багтаан танилцуулахыг Монгол Улсын Засгийн газар /Г.Занданшатар/-т даалгасугай.	Засгийн газар (ССАЖЗЯ)
12.	Засгийн газарт чиглэл өгөх тухай 2017.06.09. №24	1.14/	Боловсролын салбарын удирдах ажилтнууд болон багш нарын ажлын хариуцлага, ёс зүйг сайжруулахад онцгойлон анхаарч, хуулийн хүрээнд хариуцлага тооцон ажиллах;	Засгийн газар (БЯ)
13.	Засгийн газарт чиглэл өгөх тухай 2017.07.05 №25	1.4/	улсын хэмжээнд ашиглалтын шаардлага хангахгүй болсон цэцэрлэгийг буулгаж, газрын байршил, зориулалтыг өөрчлөхгүйгээр шинээр барих;	Засгийн газар (БЯ)
		1.9/	цэцэрлэгийн туслах багшийг Мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төвд бэлтгэх;	Засгийн газар (БЯ)
14.	Соёл, урлагийн салбарын талаар авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай 2018.10.16 №21	1.1/	Соёлын тухай хуулийн шинэчилсэн найруулга болон Музейн тухай, Киноны тухай анхдагч хуулийн төслийг боловсруулан 2018 оны намрын ээлжит чуулганы хугацаанд Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх, Соёлын өвийг хамгаалах тухай хуульд Засгийн газраас батлахаар заасан журмыг боловсруулан баталж, хэрэгжилтийг хангах;	Засгийн газар (ССАЖЗЯ)
		1.6/	хүүхэд, залуучуудад монгол ахуй, монгол өв соёлыг өвлүүлэх, дархлааг бий болгох үүднээс хүүхдүүдэд музейг үнэ төлбөргүй үзүүлдэг байх, хүүхэд, залуучуудын театр, хүүхэлдэйн театр, киноны хүрээлэн бүхий чөлөөт цагийн төв цогцолборыг байгуулах ажлыг эхлүүлэх, хилийн чанад дахь монгол хүүхдэд хэл, соёлоо өвлүүлэн үлдээх чиглэлээр гадаад, дотоодын байгууллагатай идэвхтэй хамтран ажиллах;	Засгийн газар (ССАЖЗЯ)
		1.8/	хууль бусаар улсын хилээр гарч алдагдсан, гадаад улсад үзэсгэлэнд явуулж эргэж	Засгийн газар

15.	Ерөнхий боловсролын сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний тухай хуулийн хэрэгжилтийг хангах зарим арга хэмжээний тухай 2021.05.25 №05		ирээгүй музейн үзмэр, эд өлгийн зүйл, соёлын өвийг сурвалжлан олох, эргүүлэн авчрах талаар холбогдох байгууллагад чиглэл өгөх, хэрэгжилтэд хяналт тавих;	(ССАЖЗЯ)
		1.9/	театр, музей, соёлын байгууллагын барилга байгууламж, газар, үл хөдлөх болон бусад хөрөнгийг бүртгэж, бүрэн бүтэн байдлыг хууль эрх зүйн хүрээнд судалж, баталгаажуулах ажлыг 2018 оны 4 дүгээр улиралд багтаан зохион байгуулж, тус Байнгын хороонд танилцуулах;	Засгийн газар (ССАЖЗЯ)
		1.10/	бүх нийтийн эх хэлний соёл, боловсролыг дэмжих, олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгсэл, гудамж талбай, хаяг, нэршил, хэрэглээнд хяналт тавих, он цагийн хувьсал өөрчлөлтөд монголын соёл устаж арилахаас хамгаалах дархлаа бий болгох чиглэлд зохих арга хэмжээ авч ажиллах.	Засгийн газар (ССАЖЗЯ)
		1.1/	Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хорооны хуралдаанаар Монгол Улсын Их Хурлын 2019 оны 53 дугаар тогтоолын хэрэгжилтийг шалгаж, холбогдох байгууллагын үйл ажиллагаатай танилцсан Ажлын хэсгийн санал, дүгнэлтийг үндэслэн Дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газар /Л.Оюун-Эрдэнэ/-т чиглэл болгосугай: 2021-2022 оны хичээлийн жилээс эхлэн бага ангийн суралцагчдыг өдрийн хоолны үйлчилгээнд хамруулах хүрээнд: 1/ сургуулийн нэг хүүхдэд ногдох үдийн хоолны зардлын нормативыг хүн амын зохистой хооллолтын талаарх зөвлөмжид заасан хэмжээ, инфляцийн түвшинтэй уялдуулан шинэчлэн баталж, 2021-2022 оны хичээлийн жилээс эхлэн хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийг шийдвэрлэх;	Засгийн газар (БЯ)
		1.2/	Ерөнхий боловсролын сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний байрыг стандарт, техникийн зохицуулалтад нийцүүлэн шинээр барих, засварлах, өргөтгөх болон стандартын шаардлага хангасан зориулалтын тоног төхөөрөмжөөр хангахад шаардагдах зардлыг шийдвэрлэх;	Засгийн газар (БЯ, СЯ)
		1.4/	мэргэжлийн хүний нөөц /хоол зүйч, тогооч/-ийг бэлтгэх, чадавхжуулах болон мэргэжил дээшлүүлэх тогтолцоог бүрдүүлэх, тэдгээрийн цалин хөлс, нийгмийн баталгааг хангах, дэмжлэг үзүүлэх асуудлаар эрх зүйн орчныг боловсронгуй болгох санал боловсруулж, холбогдох хууль, тогтоолын төслийг УИХ-д өргөн мэдүүлэх;	Засгийн газар (БЯ)
		1.5/	энэ тогтоолын 1.1, 1.2, 1.3, 1.4 дэх дэд заалтад заасан арга хэмжээг хэрэгжүүлэхтэй холбоотой төсөвт нэмж шаардагдаж байгаа зардлыг холбогдох төсвийн ерөнхийлөн захирагч нарын 2021 онд батлагдсан төсөвт зохицуулалт хийх замаар шийдвэрлэх;	Засгийн газар (БЯ, СЯ)
		1.6/	Хууль, тогтоолын хэрэгжилтийг эрчимжүүлэх хүрээнд: Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 1 дүгээр сарын 20-ны өдрийн 18 дугаар	Засгийн газар (БЯ, СЯ)

			тогтоолын хавсралтаар баталсан "Ерөнхий боловсролын сургуулиудыг үдийн хоол үйлдвэрлэлд үе шаттайгаар хамруулах ажлын төлөвлөгөө"-г хэрэгжүүлэхэд шаардагдах төсөв, санхүүжилтийн эх үүсвэрийг 2022 оны Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөнд тусган батлуулах;	
		1.8/	багш, ажилчид, эцэг, эх, асран хамгаалагчийн хоол, шим тэжээлийн ойлголт, мэдлэгийг дээшлүүлэх чиглэлээр сургалт, сурталчилгааг өргөжүүлэх талаар арга хэмжээний санал боловсруулж, хэрэгжүүлэх;	Засгийн газар (БЯ)
		1.10/	орон нутгийн болон үндэсний үйлдвэрлэлийг дэмжсэн, аюулгүй хүнсний ханган нийлүүлэлтийн тогтолцоог бий болгох, сургуулийн хоол үйлдвэрлэлд ашиглах хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний худалдан авах ажиллагааг ерөнхий гэрээний дагуу зохион байгуулах ажлыг эхлүүлэх;	Засгийн газар (БЯ)
16.	Биеийн тамир, спортын тухай хуулийн хэрэгжилтийг хангах зарим арга хэмжээний тухай 2021.10.19 №08	1.5/	бүх шатны боловсролын сургалтын байгууллагын биеийн тамирын хичээлийн хөтөлбөр агуулгыг боловсронгуй болгох, тоног төхөөрөмж, материаллаг баазыг бэхжүүлэх, суралцагчдыг спортын секц, дугуйланд хамран суралцуулах бололцоог бүрдүүлэх талаар холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлэх;	Засгийн газар (БЯ, ССАЖЗЯ)
		1.6/	Биеийн тамирын багш, дасгалжуулагч, арга зүйч, мэргэжилтэн бэлтгэх сургалтын хөтөлбөрийг боловсронгуй болгох, тэдгээрийг гадаад улсад бэлтгэх, мэргэшүүлэх чиглэлээр холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлэх;	Засгийн газар (БЯ, ССАЖЗЯ)
		1.7/	Монгол Улсын үндэсний шигшээ багийн тамирчдын бэлтгэл, сургуулилт хийх орчин, нөхцөлийг сайжруулах зорилгоор "Үндэсний шигшээ багийн бэлтгэл сургалтын төв"-ийг байгуулах ажлыг шуурхай зохион байгуулах;	Засгийн газар (ССАЖЗЯ)
		1.8/	Спортын анагаах ухаан, эрдэм шинжилгээний төвийн үйл ажиллагааг өргөжүүлэх, их сургуулиудад спортын шинжлэх ухаан, биеийн тамирын судалгааны лаборатори байгуулах асуудлыг судалж, холбогдох арга хэмжээг авах;	Засгийн газар (ССАЖЗЯ)
		1.9/	Биеийн тамир, спортын тухай хуульд заасны дагуу спортын холбоодын баталж мөрдүүлж байгаа тамирчдын ёс зүйн дүрмийг шинэчилж, ёс зүйн алдаа зөрчил гаргасан тамирчин, дасгалжуулагч, шүүгчдэд ногдуулах хариуцлагыг тодорхой болгох;	Засгийн газар (ССАЖЗЯ)
		1.11/	Биеийн тамир, спортын салбарын төрийн өмчлөлд байсан газар, барилга байгууламжийг төрийн өмчид буцаан авах асуудлыг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд шуурхай шийдвэрлэх;	Засгийн газар (ССАЖЗЯ)
17.	"Монгол Улсын 2021 оны төсвийн тухай хууль баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай" Улсын Их Хурлын	1.6/	Төсөл, хөтөлбөрийн гүйцэтгэлд аудит хийлгэн, аудитын дүгнэлтэд үндэслэн шаардлагатай арга хэмжээг тухай бүр авч хэрэгжүүлэх.	Засгийн газар (СЯ)

	2020 оны 39 дүгээр тогтоолын 1 дэх заалтын 5 дахь дэд заалтын хэрэгжилтийг хангах зарим арга хэмжээний тухай 2022.01.17. №01			
18.	Хүүхдийг тамхины хор хөнөөлөөс сэргийлэх зарим арга хэмжээний тухай 2022.05.11 №06	1.1/	Дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газарт чиглэл болгосугай: 1/ Тамхины хяналтын тухай хэрэгжилтийг эрчимжүүлж, бүх шатны боловсрол, сургалтын байгууллагын суралцагчдыг дам тамхидалтаас үүдэлтэй сөрөг үр дагавраас хамгаалах арга хэмжээг авах;	Засгийн газар (БЯ, ЭМЯ)
		1.2/	насанд хүрээгүй иргэнийг тамхины хор хөнөөлөөс хамгаалах, хүн амын тамхины хэрэглээг бууруулах зорилгоор импортоор оруулж байгаа болон Монгол Улсын нутаг дэвсгэрт үйлдвэрлэж байгаа тамхины доторх хорт бодисын агууламжийг харгалзан шаталсан хэлбэрээр төрөл тус бүрд онцгой албан татвар ногдуулдаг байх эрх зүйн орчныг бүрдүүлэх арга хэмжээг нэн даруй авч хэрэгжүүлэх;	Засгийн газар (СЯ)
		1.3/	холбогдох хууль тогтоомжид электрон тамхи болон бусад шинэ төрлийн тамхи тус бүрийн тухай ойлголтыг тодорхойлж, түүний хэрэглээг зохицуулахтай холбоотой эрх зүйн одоогийн зохицуулалтуудад холбогдох нэмэлт өөрчлөлт оруулах хуулийн төслийг боловсруулж, УИХ-ын 2022 оны хаврын ээлжит чуулганы хугацаанд өргөн мэдүүлэх;	Засгийн газар (ЭМЯ, ХЗДХЯ)
		1.4/	хүүхдэд үйлчилдэг болон хүүхдийн чөлөөт цагаа өнгөрүүлдэг байгууллагыг тамхигүй орчин болгох, дам тамхидалтаас сэргийлэх чиглэлээр холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлэх.	Засгийн газар (ЭМЯ)
19.	Чиглэл өгөх тухай 2025.03.26 №03	1.1	Боловсролын ерөнхий хууль болон Дээд боловсролын тухай хуулийн хэрэгжилтийг хангах, Засгийн газрын 2024 оны 102 дугаар тогтоолын хавсралтаар баталсан Гадаадын болон дотоодын дээд боловсролын сургалтын байгууллагад суралцагчид тэтгэлэг, зээл олгох, эргэн төлүүлэх, буцалтгүй тусламж олгох, дэмжлэг үзүүлэх журмыг боловсронгуй болгох ажлын хүрээнд дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газар (Л.Оюун-Эрдэнэ)-т даалгасугай. 1/1 Боловсролын зээлийн сангийн үйл ажиллагаанд олон улсын сайн туршлага, жишгийг нэвтрүүлэх арга хэмжээг авч урт хугацаанд тогтвортой мөрдөгдөх зохицуулалтыг тусгах;	Засгийн газар (БЯ)
		1.2	суралцагчдад тэтгэлэг, зээл буцалтгүй тусламж олгохдоо ил тод, нээлттэй, шударга, ашиг сонирхлын зөрчлөөс ангид, үндэслэл бүхий байх зарчмыг баримтлах;	Засгийн газар (БЯ)
		1.3	Тогтоосон шалгуур, шаардлагыг хангасан суралцагчдад тэтгэлэг, зээл, буцалтгүй	Засгийн газар (БЯ)

	тусламж олгохдоо Засгийн газраас баталсан боловсролын тэргүүлэх чиглэл, эрэлттэй мэргэжил, хөдөлмөрийн зах зээлийн эрэлт хэрэгцээгээр эрэмбэлсэн зохицуулалтыг тусгах;	
1.4	Зорилтот бүлэгт чиглэсэн буцалтгүй тусламжийг оновчтой бөгөөд тэгш, хүртээмжтэй хуваарилах, ялгаварлан гадуурхалтаас ангид байх;	Засгийн газар (БЯ)
1.5	Гадаадын сургалтын байгууллагад суралцагчдыг сургуулиа төгсөж, эх орондоо ирэхээс өмнө мэргэжлээрээ тухайн орон, олон улсын байгууллагад туршлага хуримтлуулах зорилгоор тодорхой хугацаанд ажиллахыг дэмжсэн, уян хатан зохицуулалтыг бий болгох;	Засгийн газар (БЯ)
1.6	боловсролын зээлийн сангийн санхүүжилтээр гадаадын сургалтын байгууллагад суралцан төгсөгчдийг эх орондоо ирэх нөхцөл, шаардлагыг тодорхойлж, тэднээс гэрээний үүргээ зөрчсөн тохиолдолд хүлээлгэх хариуцлагын оновчтой механизмыг бүрдүүлэх;	Засгийн газар (БЯ)
1.7	журмыг боловсруулахдаа Монгол Улсын хууль тогтоомж, холбогдох эрх зүйн актуудтай нийцүүлэх, бүтэц, системчлэл оновчтой, давхардал хийдэлгүй, ойлгомжтойгоор томьёолж батлах;	Засгийн газар (БЯ)
1.8	суралцагчийг сонгон шалгаруулахдаа аливаа нөлөөлөл, ашиг сонирхлоос ангид байх, элсэн суралцах сургуулийн эрэмбэ, сургалтын төлбөрийн хэмжээ, суралцагчийн авсан тэтгэлгийн хувь хэмжээ зэрэг үзүүлэлтүүдийг нарийвчлан тусгах;	Засгийн газар (БЯ)
1.9	Дэлхийн шилдэг их сургуулиудын сургалтын төлбөрийн тодорхой хувийг гадаад, дотоодын бусад эх үүсвэрээс бүрдүүлсэн суралцагчийн үлдсэн төлбөрийг хэрхэн шийдвэрлэх зохицуулалтыг тодорхой тусгах;	Засгийн газар (БЯ)
1.10	Зээлийн эргэн төлөлтийн нөхцөл журмыг тодорхой болгох, хөндлөнгийн хяналтын механизмыг бий болгон нэвтрүүлэх, үүргээ зөрчсөн, хариуцлага алдсан тохиолдолд түүнийг шийдвэрлэх арга замыг тодорхой заах;	Засгийн газар (БЯ)
1.11	Боловсролын зээлийн сангийн санхүүжилтийн тогтвортой байдлыг хангах, сангийн хөрөнгийг бүрдүүлэх ажлын хүрээнд зээлийн эргэн төлөлтийг сайжруулах;	Засгийн газар (БЯ)
1.12	Дотоод болон гадаадын сургалтын байгууллагад суралцаж буй суралцагч зээлийн гэрээний үүргээ зөрчсөн тохиолдолд мэдээллийг ялгаварлалгүйгээр Монголбанкны зээлийн мэдээллийн санд бүртгэлжүүлэх, хэрэгжилт болон хариуцлагын тогтолцоог сайжруулах;	Засгийн газар (БЯ)
1.13	Засгийн газраас 2024 оны 103 тоот тогтоолоор баталсан "Багш, багш мэргэжлээр суралцагч болон багш, ажилтны хүүхдийг тэргүүлэх, эрэлттэй мэргэжлээр суралцахад төрөөс дэмжлэг үзүүлэх журам"-ыг шинэчлэн боловсронгуй болгох;	Засгийн газар (БЯ)

		1.14	Малчнаас 10-аас доошгүй жил тасралтгүй ажилласан малчны 1 хүүхдийг мал аж ахуйн тэжээл, бэлчээр судлалын чиглэлээр төрийн өмчийн дээд боловсролын сургалтын байгууллагад үнэ төлбөргүй сургах журмыг боловсруулан батлуулах;	Засгийн газар (БЯ)
		1.15	Монгол Улсад дутагдалтай байгаа хөгжлийн бэрхшээлтэй иргэнтэй ажилладаг мэргэжилтэн бэлтгэхийг дэмжих хүрээнд хэл засалч, хөдөлгөөн засалч, протез техникч, хөдөлмөр засалч зэрэг мэргэжлүүдийг тэргүүлэх болон эрэлттэй мэргэжлийн жагсаалтад оруулах, уг мэргэжлээр суралцаж төгссөн иргэдийг боловсролын байгууллагаас гадна, сургалтын эмнэлэг, сувилал, сэргээн засах төв эмнэлэг зэрэг байгууллагуудад ажиллах тохиолдолд дахин 1 удаа давтан суралцуулахыг дэмжих зохицуулалтыг тусгах.	Засгийн газар (БЯ)
		2	Энэ тогтоолын биелэлтийг намрын ээлжит чуулганы хугацаанд багтаан Улсын Их Хурлын БСШУСБХ-нд танилцуулахыг Монгол Улсын Засгийн газар /Л.Оюун-Эрдэнэ/-т үүрэг болгосугай.	Засгийн газар (БЯ)
20.	Чиглэл өгөх тухай 2025.05.07 №04	1.1	Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.2.1-д заасан зорилтын хэрэгжилтийг хангуулах болон Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хорооны 2024 оны 01 дүгээр тогтоолоор байгуулсан Төрийн өмчийн ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэг, дотуур байрны нүхэн жорлонг орчин үеийн стандарт, шаардлагад нийцсэн ариун цэврийн байгууламжаар солих ажилд дэмжлэг үзүүлэх үүрэг бүхий ажлын хэсгийн хяналт шалгалтын үр дүнг үндэслэн дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газар (Л.Оюун-Эрдэнэ)-т даалгасугай: 1/Санхүү, хөрөнгө оруулалтын талаар: 1.1.Төрийн өмчийн ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэг, дотуур байрны ариун цэврийн байгууламжийн ашиглалтын тогтмол зардлыг холбогдох холбогдох төсөвт тусган, тогтвортой санхүүжилтийн эх үүсвэртэй болгох;	Засгийн газар (БЯ, СЯ)
		1.2	Бага оврын цэвэрлэх байгууламжийн бохир соруулах, лаг зайлуулах машин, техникийн зэрэг ашиглалтын санхүүжилтийг цогцоор нь шийдвэрлэх;	Засгийн газар (БЯ, СЯ)
		1.3	Цахилгаан, эрчим хүчний хэлбэлзэлтэй байгаа сумыг найдвартай цахилгаан хангамжаар хангах санхүүжилтийн асуудлыг шийдвэрлэх арга хэмжээ авахыг аймгийн Засаг дарга нарт үүрэг болгож, зохих арга хэмжээг авч хэрэгжүүлэх;	Засгийн газар
		2.1	2/Авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар: 1."Шинэ сум" төслийн хүрээнд баригдаж буй цэвэр, бохир усны төв шугамын бүтээн байгуулалтыг яаралтай ашиглалтад оруулж, шаардлагатай сумыг цаг уур, хөрсний нөхцөл байдалд тохируулан цэвэр ус түгээх болон бохир ус татан зайлуулах тусгай зориулалтын тээврийн хэрэгслээр хангах улмаар бүх сумыг	Засгийн газар (ХББОСЯ)

			цэвэр, бохир ус, дулаан хангамжийн төвлөрсөн системтэй болгох арга хэмжээг шат дараалалтай хэрэгжүүлэх;	
		2.2	Орон нутагт хэрэгжүүлж буй Сургууль, цэцэрлэг, дотуур байрны ариун цэврийн байгууламж барих төсөл, хөтөлбөрийн бүтээн байгуулалтын явцад тогтмол хяналт тавьж, ашиглалтыг сайжруулан ажиллахыг аймаг, сумын Засаг дарга нарт үүрэг болгох;	Засгийн газар
		2.3	Төрийн өмчийн ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэг, дотуур байрны ариун цэврийн байгууламжийн засвар, үйлчилгээний мэргэжлийн хүний нөөцийг бэлтгэх, чадавхжуулах сургалтыг тогтмол зохион байгуулж, гарын авлага болон ашиглалтын зааварчилгааг боловсруулан хүргэх, байршуулах;	Засгийн газар (БЯ)
		2.4	Төрийн өмчийн ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэг, дотуур байрны ариун цэврийн байгууламжийн зураг, төсөл, барилгын гүйцэтгэлийг хангалтгүй хэрэгжүүлсэн аж ахуйн нэгж, байгууллагад хариуцлага тооцож, холбогдох хуульд заасан арга хэмжээг авах;	Засгийн газар (БЯ)
		2.5	2025 онд багтаан ариун цэврийн байгууламжийн Төрийн өмчийн ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэг, дотуур байрны ариун цэврийн байгууламжийн барилга, бүтээн байгуулалтын ажлыг бүрэн дуусгаж, ашиглалтад оруулж орон нутагт хүлээлгэн өгөх;	Засгийн газар (БЯ)
		2.6	Аймгийн Засаг дарга нартай байгуулдаг Засгийн газрын зарим чиг үүргийг орон нутагт төлөөлөн хэрэгжүүлэх тухай гэрээнд энэ тогтоолын 2 дугаарт заасан "авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар" асуудлуудыг тусгаж оруулах.	Засгийн газар (БЯ)
		2	Энэхүү тогтоолын биелэлтийг БСШУСБХ-нд намрын ээлжит чуулганы хугацаанд багтаан танилцуулахыг Монгол Улсын Засгийн газар /Л.Оюун-Эрдэнэ/-т үүрэг болгосугай.	Засгийн газар (БЯ)

----- оОо -----